



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2020 • 01 • № 41

С.ДЭМБЭРЭЛ:

ВАЛЮТЫН ХАНШ ЗАСГИЙН
ГАЗРЫН БОДЛОГЫН
ҮЙЛДЛҮҮДЭЭС МАШ ИХ
ХАМААРДАГ

САНХҮҮГИЙН
ЗАЛИЛАНГААС
СЭРГИЙЛЭХИЙН ТУЛД
ХАРИЛЦАГЧИД ЮУНД
АНХААРАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС:
МӨНГӨН ТОНОГТОЙ ХОС БИШГҮҮР

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

ЯТГАХ ТУСАМ

НЯГҒАЛ!



**ЗАЛИЛАГЧААС
БОЛГООМЖИЛ**



**залилагчдад
боломж бүү олго!**

ИТГЭЛ ТӨРҮҮЛЭХҮЙЦ

Эхлээд ажлын байр машинтай тогтвортой утастай, бүх төрлийн мэдээлэл сайтай мэт.

АЖИЛ ХЭРЭГЧ ДҮРТЭЙ

Нэг л их ажил ярьсан, ажил зохицуулсан завгүй царйлдаг.

ТУСАРХУУ БАЙДАЛТАЙ

Хүн бүрийн төлөө санаа тавьсан, өөрийгөө үл хайхарсан мэт.

БОЛОВСОН ХАРЬЦААТАЙ

Найрсаг, нээлттэй, хүнийг хүндэлсэн, уран үгтэй, биелэгдэшгүй амлалт хэлсэн

ХЭЛДЭГ ҮГНҮҮД

Танд би л тусалж чадна, ашигтай, болгоно бүтээнэ, асуудалгүй.

ХҮН ЧАНАРГҮЙ

Өвчин зовлон, уй гашуу, хүүхэд, өндөр настан хэнийг ч ялгахгүй түүнд зөвхөн мөнгө хэрэгтэй.

ЗАН БАЙДАЛ

Гярхай, овжин, төсөөлөн ярих чадвартай, уйгагүй тэмүүлэлтэй зүтгэдэг/мөнгөний төлөө/

ТАНЫГ ТУЛГАЖ ЯАРУУЛНА

Яг одоо мөнгөө шилжүүл, яг одоо ажил бүтлээ хурдан гэх мэт.

ЕРӨНХИЙДӨӨ ХОВСДОГЧ

Сэтгэх, бодох завдал өгөхгүй, нэг мэдэхэд та мөнгөө өгсөн байна.

Онцлох үйл явдал:

ХУУДАС

Монголбанкны
Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн
АНУ-ын Сангийн яамны
Азийн асуудал эрхэлсэн
дэд сайд Роберт Капротыг
хүлээн авч уулзлаа

4

Тодруулга:

ХУУДАС

"Ариг" банкинд нөхцөлт
удирдлагын арга хэмжээ
авч Бүрэн эрхт төлөөлөгч
томилов

5

Ярилцлага:

ХУУДАС

С.Дэмбэрэл: Валютын ханш
Засгийн газрын бодлогын
үйлдлүүдээс маш их
хамаардаг

6

Асуулт, хариулт:

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн
бага хурлаас

10

Нийтлэл:

ХУУДАС

Коронавирус эдийн засаг ба
ард иргэдийн сэтгэл зүйд
хэрхэн нөлөөлөх вэ?

18

**Монголбанкны
мэдээлэл:**

ХУУДАС

Нэгдүгээр сард 3,558 кг
үнэт металл худалдан авлаа

22

Байр, суурь:

ХУУДАС

Санхүүгийн залилангаас
сэргийлэхийн тулд
харилцагчид юунд анхаарах
хэрэгтэй вэ?

23

**Монголбанк
юу хийдэг вэ?**

ХУУДАС

А.Энхжин: Төгрөгийн
ханшид нөлөөлж байсан
гадаад, дотоод хүчин зүйлс
эерэг чиглэлд өөрчлөгдсөн

24

Дэлхийн эдийн засаг:

ХУУДАС

Давос-2020 ба дэлхийн
эдийн засгийн төлөв

29

**Мөнгөн тэмдэгтийн
түүх:**

ХУУДАС

Сайжруулж, шинэчилсэн
50, 20000 төгрөгийн
дэвсгэртүүд

32

Банкир:

ХУУДАС

Виктория Кваква: Монгол
Улс урт зам тууллаа-Одоо
эдгээр ололтыг бэхжүүлэхэд
юу шаардлагатай вэ?

34

Судалгаа шинжилгээ:

ХУУДАС

Монгол Улсын эрдэс
баялгийн орлогын
менежментийг сайжруулахад
анхаарах асуудлууд

36



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН АНУ-ЫН САНГИЙН ЯАМНЫ АЗИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ДЭД САЙД РОБЕРТ КАПРОТЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА.

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдлагуудын хамтаар АНУ-ын Сангийн яамны Азийн асуудал эрхэлсэн дэд сайд Роберт Капрот болон албаны бусад төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал болон Монгол Улсын Засгийн газрын ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үйл явцын талаар мэдээлэл солилцов. Энэ үеэр Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Монгол Улс Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын эрчимтэй хяналтаас 2020 онд багтаж гарахаар зорьж ажиллаж буй талаараа онцолсон бол АНУ-ын зүгээс Монгол Улсыг ФАТФ-ын Эрчимтэй хяналтаас гарахад нь дэмжиж ажиллахад бэлэн байгаагаа мөн илэрхийлэв.



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ ӨСЧ, ТҮҮХЭН ДЭЭД ТҮВШИНД ХҮРЛЭЭ

Монгол Улсын гадаад худалдааны ашиг 2019 оны эхний 11 сард 1.5 тэрбум ам.долларт хүрч өслөө. Ийнхүү гадаад худалдааны ашиг нэмэгдсэн нь гадаад валютын албан нөөц (ГВАН) хуримтлагдахад эерэгээр нөлөөлж, 2019 оны 12 дугаар сарын байдлаар гадаад валютын албан нөөц 4.3 тэрбум ам.долларт хүрээд байна. Засгийн газар, Олон Улсын Валютын Сантай хамтран хэрэгжүүлж буй Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн хүрээнд донор байгууллагуудаас Монгол Улсын Засгийн газарт нийт 200 сая ам.долларын санхүүжилтийг олгосноор ГВАН түүхэн дээд хэмжээнд хүрэв. Тухайлбал, Азийн Хөгжлийн Банк 100 сая ам.доллар, Дэлхийн банкнаас нийт 100 сая ам.долларын санхүүжилт хийжээ.



ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙГ МОНГОЛ ХЭЛ РҮҮ ОРЧУУЛЛАА

Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанаас Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт (ФАТФ-ын 40 Зөвлөмж)-ыг орчууллаа.

Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр мэдээлэх үүрэгтэй этгээдийн хамрах хүрээг өргөжүүлсэнтэй холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 онд баталсан “Санхүүгийн мэдээллийн албанд банкнаас мэдээлэл ирүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгчийн А-326 дугаартай тушаалаар “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-ыг батлав.



ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ 2019 ОНД 18.1 ХУВИАР БУУРАВ

Банкууд 2019 оны 12 дугаар сарын 31-ий өдрийн байдлаар 228.7 мянган зээлийн дансанд 757.9 тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй байв. Энэ нь 2018 оны эцэстэй харьцуулахад 167.5 тэрбум төгрөг буюу 18.1 хувиар буурсан үзүүлэлт юм. Нэг зээлдэгчид ногдох тэтгэврийн зээлийн хэмжээ дунджаар 3.3 сая төгрөг байна.

Тэтгэвэр барьцаалсан зээлдэгчдийн 20.1 хувь нь 3.0 сая хүртэлх төгрөгийн, 55.1 хувь нь 3.0-6.0 сая хүртэлх төгрөгийн, 15.4 хувь нь 6.0-10.0 сая хүртэлх төгрөгийн, 9.4 хувь нь 10.0 саяаас дээш төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байжээ. Харин 2019 оны 12 дугаар сард өмнөх саруудын дундажтай ижил хэмжээний буюу 55 тэрбум төгрөгийн зээл шинээр гарчээ. Энэ нь 2019 оны 11 дүгээр сарын дүнгээс 1 тэрбум төгрөгөөр бага дүн байв.



АРИГ БАНКИНД НӨХЦӨЛТ УДИРДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ АВЧ БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ ТОМИЛОВ

Ариг банк Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, хувь нийлүүлэгчдийн хооронд маргаан үүссэнээс хувьцаа эзэмшигчдийн хурлаар маргаантай асуудлаа шийдвэрлэж чадахгүй, төлөөлөн удирдах зөвлөл эрх зүйн чадамжгүй болсон тул зохистой засаглал алдагдсан. Иймд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн тушаалаар харилцагч, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалах үүднээс Банкны тухай хуульд заасны дагуу нөхцөлт удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлэхээр боллоо. Ариг банкнаас ирүүлсэн мэдээллээр 2019 оны эцсийн байдлаар тус банк Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг хангаж байна.

Бүрэн эрхт төлөөлөгч нь Ариг банкны үйл ажиллагааг хүлээж авсан бөгөөд 1 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна.



ХШГ-ын захирал Н.Батсайхан:

Ариг банкны хувь нийлүүлэгчдийн хооронд үүссэн маргаан нь хувь нийлүүлэгчдийн хурлаа хийж чадахгүйд хүргэсэн. Үүний улмаас Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь бүрэн томилогдож чадахгүй, хууль эрх зүйн чадамжгүй болж, тухайн банкинд зохистой засаглал алдагдсан учраас Монголбанк хуульд заагдсан үүргийнхээ дагуу харилцагч, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалах зорилгоор тус банкинд нөхцөлт удирдлагын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайн банк нь 2019 оны эцсийн байдлаар ирүүлсэн тайлангаар Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг хангаж байгаа. Тийм учраас Монголбанкны бүрэн эрхт төлөөлөгч тухайн банкны үйл ажиллагааг 1 дүгээр сарын 17-нд хүлээн авч, 20-ны өдрөөс эхлэн үйл ажиллагааг нь хэвийн үргэлжлүүлж байна. Тус банкны санхүүгийн үзүүлэлтүүд хэвийн учраас Бүрэн эрхт төлөөлөгч (БЭТ) нь түр хугацаанд банкны удирдлагыг хүлээн авч, зохистой засаглалыг сэргээж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсний дараа үйл ажиллагаагаа дуусгавар болгож, буцаан татагдана. Тэгэхээр тухайн банкны харилцагч, хадгаламж эзэмшигч нар тайван байж, албан бус мэдээ, цуурхалд автахгүй байхыг хүсье.

"Ариг" банк банкны системийн хэчнээн хувийг бүрдүүлдэг вэ, Бүрэн эрхт төлөөлөгч хэдий хугацаанд тус банкинд ажиллах вэ. Мөн хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд мэдээлэл өгөх боломжтой юу?

"Ариг" банк нь банкны системийн 0.3 хувийг бүрдүүлдэг. Тус банк нөлөө бүхий хоёр хувь нийлүүлэгчтэй. Нэг нь 61 хувь, нөгөө нь 39 хувийг эзэмшдэг. Нөхцөлт удирдлагын арга хэмжээг 6 сарын хугацаанд авч хэрэгжүүлнэ.

Ариг банкинд арга хэмжээ авсан тухай хэвлэлийн бага хурлын үеэр Монголбанкны Хяналт шалгалт /ХШГ/-ын газрын захирал Н.Батсайхан, Хууль эрх зүйн газар /ХЭЗГ/-ын захирал Д.Аюуш нарын өгсөн тайлбар мэдээллийг уншигч танд хүргэж байна.

Бүрэн эрхт төлөөлөгчийг Монголбанкнаас томилсон уу, БЭТ тус банкинд дээр яг ямар үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх вэ?

ХЭЗГ-ын захирал Д.Аюуш:

Бүрэн эрхт төлөөлөгч хуулийн дагуу Монголбанкнаас томилогдож болно. БЭТ нь тус банкинд зөвхөн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Банкны тухай хуулийн 52 дугаар зүйлд Бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах чиг үүрэг, хүрээг тодорхой зааж өгсөн. Тодруулж хэлэхэд, Бүрэн эрхт төлөөлөгч болон Банкны эрх хүлээн авагч нь хоёр өөр чиг үүрэгтэй. БЭТ буюу зөвхөн удирдлагын буюу шийдвэр гаргалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Энд банк татан буугдах асуудал яригдахгүй. Хуулиараа БЭТ-ийг нэг жил хүртэлх хугацаагаар томилдог.

Монголбанкны Ерөнхийлөгч Ариг банкинд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх үүрэг даалгавар өгсөн юм уу, яг ямар үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй байгаа гэж үзсэн бэ?

ХЭЗГ-ын захирал Д.Аюуш:

Өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх болон газар дээрх иж бүрэн шалгалтаар нэлээд олон үүрэг, даалгаврыг өгсөн. Өнөөдрийн байдлаар Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлд заагдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд бараг бүгд авагдсан. Мөн гүйцэтгэх удирдлага шийдвэрээ гаргахтай холбоотой нэлээд олон үүрэг даалгавар өгөгдсөн ч, харамсалтай нь хийгдээгүй байна. Тийм учраас Банкны тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу нөхцөлт удирдлагын арга хэмжээг авах болсон. Энэ нь банк татан буугдаж байна гэсэн үг биш юм.



С.ДЭМБЭРЭЛ: ВАЛЮТЫН ХАНШ ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГЫН ҮЙЛДЛҮҮДЭЭС МАШ ИХ ХАМААРДАГ

Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэлтэй ярилцлаа.

- ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭНГЭЭС МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГЛЭЛЭЭР СУДАЛГААНУУД ХИЙЖ, БОДЛОГО ТОДОРХОЙЛОГЧИД БОЛОН ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛДАГ. ХАМГИЙН СҮҮЛД ЯМАР СУДАЛГААНД АЖИЛЛАЖ БАЙНА ДАА?

-Хамгийн сүүлд эдийн засаг, нийгмийн өргөн асуудлуудыг хамруулсан 2019 оны урьдчилсан байдал, 2020 оны төлөв гэсэн судалгаан дээр ажиллаж, бэлэн болгоод байна. Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн гэсэн нэртэй учраас үүнийг уламжлал болгох хэрэгтэй гэж бодсон. Энэ хүрээнд макро эдийн засаг, улсын төсөв, өрхийн эдийн засаг, валютын ханшийн асуудлуудад судалгаагаа төвлөрүүлж байгаа. 2020 оны судалгааны гол чиглэл гэвэл эдийн засгийн гүйцэтгэлийн тоймыг улирал бүр гаргахаас гадна ханшийн бодлого, хүлээлтэд тулгуурлана. Жилийн эцсээр гаргадаг макро эдийн засгийн үндэсний тооцооныхоо тоо баримтуудыг ашиглан эдийн засгийн секторууд буюу өрхийн,

бизнесийн, Засгийн газрын гэх мэт сектор бүрээр нь ангилсан судалгааг Үндэсний Статистикийн Хороотой хамтран хийхээр болсон. Дээр нь инфляцын судалгааг гүнзгийрүүлж хийхгүй бол үнийн системээ бүхэлд нь харж чадахгүй байна. Түүнчлэн бидэнд хамгийн ойр мөртлөө зайтай яваад байгаа нэг ойлголт бол мөнгөний эдийн засаг. Монголбанкны сар бүрийн тоо баримт мөнгөний эдийн засгийг хэлээд байдаг. Гэтэл мөнгөний үзүүлэлтүүд бодит эдийн засагтайгаа хэрхэн уялддаг талаарх ойлголт нийгэмд тааруу байна.

-ТЭГВЭЛ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ӨРХ БҮРИЙН ҮҮДЭЭР ОРОХ ЁСТОЙ ГЭДЭГ ОЙЛГОЛТ БИЙ. ЕР НЬ ӨРХИЙН АМЬЖИРГАА ЯМАР ТҮВШИНД БАЙНА ВЭ?

-Хоёр дахь жилдээ хийсэн «Өрхийн эдийн засгийн аж байдлын судалгаа»-г арай илүү шинэлэг байдлаар явуулахаар төлөвлөж байна. Өрхийн эдийн засгийн судалгаан дээрээ үндэслэн дундаж ангийг гүнзгийрүүлэн

судална гэсэн үг. УИХ, Засгийн газрын түвшинд 2050 оны урт хугацааны төлөвлөгөөний тухай яригдаж байна. Түүнд дундаж давхаргыг 80 хувьд хүргэнэ гэж дурдсан байна лээ. Одоо байгаа хөгжлийн баримт бичгээр бол 2030 он гэхэд дундаж давхаргаа 80 хувьд хүргэнэ гэж тусгажээ. Гэтэл өнөөдөр хүн амын хэдэн хувь нь яг дундаж ангилалдаа багтаж байгаа юм. Хэн, ямар аргачлалаар үүнийг гаргав. Ер нь хэрэглээ, орлого талаас нь тооцоод, дундаж анги гэж тодорхойлох нийтлэг хандлага бий. Тэгэхээр дундаж анги гэж хэрэглээ төдийгүй авир төрөхийн хувьд яг ямар ангийг дундаж гэж нэрлэж байгаа зэрэг асуулт нээлттэй үлддэг.

Нэг хүнд ногдох худалдан авах чадвараар харьцуулсан ам.долларын хэмжээ гэх мэт бусад оронтой жишсэн судалгаа байна л даа. Энэ аргачлалаар гаргасан судалгааны дүнгээр Монгол Улсын дундаж давхарга 53 хувьтай гарч байгаа. Улмаар 2030 он гэхэд 80 хувьд хүрнэ. Гэхдээ өнөөдрийн 53 хувьд яг ямар хүмүүс багтаж байна гэхээр миний хувьд эргэлзээтэй. Өрхүүдийн байр байдлаар жишээлбэл, дундаж өрхийн хүнсний хэрэглээ зарлагынх нь хэдэн хувийг эзэлж байгаа юм. Статистикийн тооцоогоор бол хэрэглээнийх нь 30 орчим хувьтай тэнцүү гардаг. Ядуу болон бага хэрэглээтэй өрхүүдийн хувьд 30-аас даваад явчихдаг. Өөрөөр хэлбэл, бага орлоготой өрхүүдийн зарцуулалтын дийлэнхийг хүнс эзэлж байгаа. Өндөр орлоготой өрхийн хүнсний хэрэглээ зарлагад нь их хувь эзэлдэггүй. Энэ нэг шалгуур нь байж болох юм. Нөгөө талаар Улаанбаатар хотын автомашины тоог харахад, 500 гаруй мянга байна. Тэдгээрийн насжилт хэдэн жил байгаа вэ. Гурав хүртэлх жилтэй нь хамгийн бага хувьтай бол 10-аас дээш насжилттай нь хамгийн өдөр хувийг эзэлж байгаа. Энэ талаас нь бодсон ч тэр. Одоо 2018 оноос хойш тооцсон орон сууцны тооллогын үр дүн удахгүй бэлэн болно. 2015 оны тооллоор хотын хүн амын 20 хувь нь л 61-81 болон түүнээс дээш ам.метр талбайтай орон сууцанд амьдарч байна. Тэгэхээр яаж ч бодсон дундаж өрхийн тоо 50 гаруй хувьтай гарах нь бодит байдалтай нийцэхгүй байна л даа. Энэ мэтээр олон судалгаагаар үгүйсгэгдэнэ. Өөрөөр хэлбэл, бодит амьдралын баримтуудыг тусгасан байдлаар дундаж ангиа тодорхойлох шаардлагатай гэсэн үг. Миний хувьд 530 гаруй мянган хүний цалингаар тооцоход, дундаж анги 25-26 хувьтай гардаг. Тиймээс энэ талынхаа судалгааг өргөжүүлнэ. Мөн бид инфляц талдаа дундаж үзүүлэлтүүдээ авч үзэж байгаа. Инфляц өнгөрсөн оны эцэст 5.2 хувьтай гарсан байна. Гэтэл хонь, үхрийн махны үнэ дунджаар 20 гаруй хувийн өсөлт үзүүлсэн. Бас Нарантуул, Дүнжингарав, сүлжээ дэлгүүрүүдэд орж буй иргэдийн хэрэглээний сагс өөр өөр байгаа. Иймд хэрэглээний бүлгүүдээр нь НӨАТ-ын системийг ашиглан инфляцыг илүү гүнзгий судлахаар ажиллаж байна. Инфляцыг илүү ул суурьтай гаргаж ирснээр Засгийн газрын бодлогын шийдвэрт дэмжлэг болно. Төв банк инфляцыг онилдог учраас мөнгөний бодлогыг

нийгмийн бүлгүүдэд чиглэсэн байдлаар хэрэгжүүлэхэд сонирхолтой үр дүн гарч болох юм.

-ӨНГӨРСӨН ХУГАЦААНД ХИЙСЭН СУДАЛГААНУУДААС ХАРАХАД, ЭДИЙН ЗАСАГ БҮТЦИЙН ХУВЬД ТЭЛСЭН ЭСЭХ, ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРАА ОЛШРУУЛАХ ЧИГЛЭЛД БОДЛОГЫН ҮР ДҮН ГАРЧ БАЙНА УУ?

-Эдийн засгийн төрөлжилт, тэр дотроо экспортын салаалжилт бол Монгол Улсын мөнхийн асуудал. Бараг судалгаа бүр дээр нэг хэвшмэл зүйл гардаг нь эдийн засгийн төрөлжилт. Экспортоо зөвхөн уул уурхайн хамаарлаас гаргамаар байна гэдэг. Гаалийн ерөнхий газраас сүүлийн таван жилийн уул уурхайн бус экспортын мэдээллийг нарийвчлан авсан. Үүн дээр үндэслэн энэ асуудлыг хөндсөн танилцуулга бэлдээд, нээлттэй хэлэлцүүлэг хийхээр төлөвлөж байна. Уул уурхайн болон бусад салбарын экспортыг 90-ийг харьцах нь 10 хувийн харьцаатай байна гэж бодъё. Энэ харьцааг яаж бууруулах талаар сайн судалгаа хийгээд, шийдэл дэвшүүлж болно. Гэтэл өнөөдөр УИХ ч тэр, Засгийн газар ч тэр Монголын эдийн засгийг төрөлжүүлэх асуудлыг яг тодорхой бодлогоор хөндөхгүй байна.

Өнгөрсөн жилийн нэгдүгээр сарын ханшийг энэ оныхтой харьцуулаад, том зургаар нь авч үзэхэд ханш зарим үед л өндөр хэлбэлзэлтэй гарсан болохоос тогтвортой байгаа гэж үзэж болно.

Стратегиараа гаргаад байдаг. Монгол Улс тэдэн онд тийм болно гэж стратеги баталдаг мөртлөө бодлогоор хэрэгжүүлэх тал дээр хойрго хандаж байгаа. Бодлогоор хэрэгжүүлэхийн тулд хөтөлбөр хоосон цаас байх ёсгүй. Нийт экспортын 10 хувийг эзэлж буй уул уурхайн бус экспортын бүтцээ задлаад харахаар, 90 хувь нь ноос, ноолуур, мах зэрэг уламжлалт бүтээгдэхүүн зонхилж байна. Тиймээс ноос, ноолуур, махаа хасаад үлдсэн хэсгийг нь бидний барьж авах ёстой асуудал байгаа гэж хардаг. Тэр нь бүтээгдэхүүнээ бага хэмжээгээр экспортод гаргадаг, эсвэл туршилтын экспортоо хийгээд зогссон компаниудаа дэмжих асуудал юм. Монголд ийм компани маш олон байна. Хувийн хэвшилд бүтээгдэхүүнээ экспортлох сонирхол байна. Тэр сэдлийг нь өдөөсөн, дэмжсэн төрийн бодлого алга. Урьд өмнө нь уул уурхайн бус экспортыг дэмжих чиглэлээр төрийн бодлого байсан уу гэвэл, байсан. Гэхдээ ихэнх нь цаасан дээрээ үлдсэн. Гол дутагдал нь зорилтод шинж чанар байхгүй, хувийн хэвшлийг оролцуулаагүй. Тодорхой бүтээгдэхүүний бүлэг дээр суурилдаагүй. Экспортын бүтээгдэхүүнийг санхүүжүүлэх тогтолцоо байхгүй зэргээс шалтгаалж ирсэн. Төрийн банк гэхэд л гадаад худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд тусгай

болзолтой зээл олгоно гэж байна. Тэгэхээр арилжааны голлох банкуудыг экспортыг дэмжихэд чиглүүлэхэд Төв банк ямар үүрэгтэй байх вэ гэдэг асуудал гарч ирж байна. Бодлого нь бүтээгдэхүүнийн бүлэг дээр суурилсан, хувийн хэвшлийн оролцоотой экспортын хөтөлбөр гаргалаа гэхэд үүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг мөнгөний бодлогын хүрээнд дэмжинэ гэсэн Төв банкны бодлого гарах ёстой.

-ЭКСПОРТОО БОДЛОГООР ДЭМЖИХ НЬ ТӨГРӨГИЙН БОДИТ ХАНШИД ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ. НӨГӨӨ ТАЛААР ТӨГРӨГИЙН ХАНШИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ ЭКСПОРТЫН ОРЛОГОО ДЭМЖДЭГ. ВАЛЮТЫН ХАНШИЙН ХЭЛБЭЛЗЛИЙГ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ ХЭРХЭН УЯЛДУУЛАН ХАРЖ БАЙНА ВЭ?

-Ханшийн асуудлаар хүмүүсийн бодол санааг сонсоод байхад, их энгийн буруу ойлголт давамгайлдаг. Жишээлбэл, Монголбанк ханшийг тогтоох ёстой мэт ярьдаг УИХ-ын гишүүд ч байна. Гэтэл ханш гэж яг юу юм. Монголын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг болон гадаад валют хоёрын солилцооны харьцааг ханш гэдэг. Олон валютын сагсан дотроос улсуудын инфляцыг харьцуулаад, нэрлэсэн болон бодит ханш гэж гаргадаг. Энгийнээр жишээлэхэд, АНУ-ын инфляцыг Монголынхтой харьцуулан бодит ханшаа гаргаж байгаа. Өнөөдрийн нөхцөлд Монголын валютын захын ханшийг хиймлээр тогтоон барьж болохгүй л дээ. Бид бол үнэ тогтоогч бус үнэ хүлээн авагч. Тиймээс ханшийн зах зээл дээрх хэт их хэлбэлзлээс сэргийлэх боломжтой. Тэр хэлбэлзэл нь бодит бус шалтгаантайгаар гарах нөхцөлийг бүрдүүлэхгүй байх нь Монголбанкны үндсэн үүрэг.

Валютын зохицуулалтын тухай гээд бүр эртний хуулийг одоо яриад байгаа. Валютын ханш Засгийн газрын бодлогын үйлдлүүдээс маш их хамаардаг. Энэ талаас нь бодсон хууль эрх зүйн орчин одоо л үүсэх гэж байна. Гэхдээ өнгөрсөн жилийн нэгдүгээр сарын ханшийг энэ оныхтой харьцуулаад, том зургаар нь авч үзэхэд ханш зарим үед л өндөр хэлбэлзэлтэй гарсан болохоос тогтвортой байгаа гэж үзэж болно. Сүүлийн үед үүсээд байгаа өөрчлөлт нь голлон спекуляци буюу баталгаатай бус мэдээлэл дээр үндэслэж зах зээлд оролцох, улирлын шинжтэй баярын нөлөө гэх мэт зүйлсээс гаралтай. Мөн төсвийн бодлого нь өөрөө ханшид нөлөөлж байна. Төсөв энэ оны эхний 3 улиралд сахилга баттай байсан ч төгсгөл рүү зарлага огцом нэмэгдсэн. 2019 онд 11.4 их наяд орчим төгрөгийн зарлага гарснаас 4 дүгээр улиралд 4 их наядыг зарцуулжээ. Иргэд ханшийг мөнгөний бодлоготой л холбож ойлгоод байдаг. Гэтэл Засгийн газрын төсвийн бодлого нь маш хүчтэй нөлөөтэй. Манайд хийсэн судалгаанаас үзэхэд төсвийн нийт зардал 1 хувиар өсөхөд тэр нь 2 сарын дараа төгрөгийн ханшийг 0.2 хувиар бууруулах нөлөөтэй. Тиймээс засгийн газар төсвийн

сахилга батаа үргэлжлүүлэн сахих хэрэгтэй. Дээр нь зах зээл дээр үймээн гарахаас сэргийлэхэд анхаармаар байна. Засгийн газрын нэг сайд гарч ирээд, "Валютын ханшийг бид бус Төв банкнаас асуу" гэдэг ч юм уу. Гэнэн бөгөөд явцуу дүгнэлт мэдэгдэл хийх нь хортой. Эсвэл их мэдэгчийн дүрд ороод, нэг тоо хэлдэг. Энэ бүхэн нь ханшид маш хүчтэй нөлөөлдөг. Ханш бол маш эмзэг зүйл учраас валютын нийлүүлэлт буюу интервенц хийх гэдэг арга хэмжээ авдаг. Сүүлийн арваад жилийн дунджаас харахад, Монголбанк валютын нийт эрэлтийн 30 хувийг хангаж байна. Энэ бол бодлого. Валютын бүх нөөцөө тавиад туучиж болохгүй шүү дээ.

-МАНАЙД ХАНШИЙГ ТӨР ХҮЧЭЭР БАРЬЖ БАЙХ ЁСТОЙ МЭТ ОЙЛГОЛТ ДАВАМГАЙЛДАГ Л ДАА. ТА ҮҮНИЙГ ЭРС ҮГҮЙСГЭЛЭЭ. ЕР НЬ ТӨР ЗАХ ЗЭЭЛД ЯАЖ ОРОЛЦОХ ЁСТОЙ ЮМ БЭ?

-Төр хэт их хамгаалалт хийгээд байвал нөхцөл байдал бүр л буруугаараа эргэнэ. Монгол шиг жижигхэн эдийн засагт худалдаа чөлөөт байх тусмаа сайн. Худалдааг аль болох хөнгөвчлөх нь Монголд хамгийн их дэмтэй. Жишээлбэл, гадаад худалдаа эрхэлдэг компаниудаас хил дээр шаарддаг бичиг баримтыг 2015 онд тав болгон цөөлж өгч байсан бол одоо эргээд 10 болсон. Хилийн алба бидэнд хэрэгтэй юм уу. Эсвэл дарга нь оймсондоо мөнгө нууж байгаад баригдаад байх ёстой юм уу. Хэтэрхий их хамгаалалт зах зээлээ гажуудуулаад байгаа юм. Түүн дотроо экспорт импортоор дамжин ханшийг хүртэл гажуудуулж байна. Гаалийн үнэлгээг ч бодолцох ёстой. Өнөөдөр Монгол Улсын хилээр орж ирж байгаа бүтээгдэхүүнийн гаалийн үнэлгээ ямар зарчмаар хийгдэж байна. Яг зах зээлийн үнэлгээндээ уялдаж чадаж байна уу. Цаашдаа үүнийг анхаарах ёстой. Гаалийн татвар өндөр байхын хэрээр улсын төсөвт их мөнгө орж ирнэ. Гэтэл яг бодит зах зээлийн үнээрээ орж ирсэн бараа хэрэглэгчийн гар дээр хямд хүрнэ. Энэ мэтээр төрийн зохицуулалт зах зээлийг гажуудуулж байгаа шигээ ханшид ч нөлөөлнө.


-ТЭГЭХЭЭР БОДИТ БАЙДАЛ ТӨРИЙН БОДЛОГО МААНЬ ХЭРЭГЖИЖ ЧАДАЖ БАЙНА УУ ГЭДЭГ АСУУЛТ ГАРЧ ИРДЭГ Л ДЭЭ. ЕР НЬ ТӨРИЙН БОДЛОГО ЯГ ХӨРСӨН ДЭЭРЭЭ ХЭРЭГЖИЖ БАЙНА УУ?

-Би бодлогын шийдвэр гаргагч байж үзсэн. Шийдвэр гаргахад нөлөөлдөг ч хүн байсан. Одоо бодлогын судалгаа хийж байна. Бодлого гаргахын тулд судалгаан дээр үндэслэх ёстой. Судалгааг хайхрахгүй байвал, бас зүгээр суугаад байж болохгүй. Идэвхтэй хандлага чухал юм. Монголын бодлого боловсруулах урлаг ерөнхийдөө доогуур түвшинд байгаа. Нийтээрээ эдийн засгийн боловсрол муу байгаа нь үүгээр ил болдог л доо. Түүнээс биш харанхуйгаар 2050 онд нэг төгрөг нэг ам.доллартай тэнцэнэ гээд биччихэж болохгүй. Манайхны хэт холын хараа их сайн байна. Харин ойрын хараа огт юм үзэхгүй байна.


Ярилцсанд баярлалаа.

ИНФЛЯЦЫН ХУАНЛИ

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн жилийн инфляц 2019 оны 12 дугаар сард Улсын хэмжээнд 5.2 хувьд, Улаанбаатар хотын хэмжээнд 5.0 хувьд хүрлээ.



Төрөөс Мөнгөний бодлогын талаар баримтлах Үндсэн чиглэлд Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2020 онд жилийн 8 хувь, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулахаар зорьж байна. Хэдийгээр инфляцын түүхэн хэлбэлзэл өндөр боловч, үнийн түвшний өөрчлөлтийг дунд хугацаанд тогтвортой байлгахад чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж байна. Инфляц 2017 оны 2 дугаар хагасаас хойш 2 жил гаруй хугацаанд төв банкны зорилтот түвшний орчимд хадгалагдаж, харьцангуй тогтвортой байна. Инфляцыг тогтвортой байлгах нь зах зээлд оролцогчдын хүлээлтийг тогтворжуулж, улмаар хүлээлтийг удирдахад дэмжлэг болно. Инфляц тогтвортой, нам дор түвшинд тогтворжсоноор зээлийн хүү буурах нөхцөл бүрдэнэ.





МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС... (2020.01.31)

Монголбанкны сар тутмын ээлжит хэвлэлийн бага хурал 2020 оны нэгдүгээр сарын 31-ний өдөр болж, санхүүгийн болон гадаад секторын статистик тойм мэдээ танилцуулахын хамт сэтгүүлчдийн сонирхсон цаг үеийн асуудлаар тайлбар, тодруулга хийв.

Блүүмбэрг ТВ:

Салхитын мөнгөний ордыг түшиглэн бонд гаргах замаар тэтгэврийн зээлийг тэглэхээр болсон нь Монголбанкны эдийн засгийн цаашдын төсөөлөлд хэрхэн тусах бол? Мөн энэ асуудал дээр Монголбанк мөнгө хэвлэнэ гэж ойлгож болох уу?

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар /НУСЗЗГ/-ын захирал А.Энхжин:



ҮАБЗ-өөс тэтгэвэр барьцаалсан зээлийг төрөөс нэг удаа тэглэх зөвлөмжийг өгч, энэ дагуу УИХ-аас хууль баталсан. Уг хуулинд Монголбанкны оролцоог тодорхой тусгаж өгсөн. Монголбанк уг хуулийг банкны салбарт сөрөг нөлөө багатайгаар, оновчтой хэрэгжүүлэх чиглэлээр ажлын хэсэгт орж ажиллаж байна. Нөгөөтэйгүүр Монголбанк дотоодын зах зээл дээрээс үнэт металл худалдаж авдаг. “Эрдэнэс Монгол” компанийн Салхитын мөнгөний ордоос олборлосон мөнгийг Монголбанк худалдан авч, цэвэршүүлнэ. “Эрдэнэс Монгол” компани бондын эргэн төлөлтөө Монголбанкинд худалдсан үнэт металлын эх үүсвэрээсээ төлнө гэсэн төсөөлөлтэй байгаа. УИХ-аас баталсан

хуулийн дагуу НДЕГ-аас тоон мэдээллээ “Эрдэнэс Монгол” компанид өгөөд, тус компани Хөгжлийн банкны баталгаатайгаар 5 жилийн хугацаатай бонд гаргана. Уг бондыг банкуудад шилжүүлж өгөх замаар иргэдийн тэтгэврийн зээлийг төлнө гэдэг байдлаар хууль хэрэгжинэ. Монголбанк Төв банкны тухай хуульд заасан чиг үүргийнхээ дагуу үүнд оролцоно. Өөрөөр хэлбэл, хуулиас гажихгүй л гэсэн үг юм.

Блүүмбэрг ТВ:

Зээлийн өсөлт жилийн дүнгээр 5 хувьд хүрч, буурсан байна. Өнгөрсөн онд 20 гаруй хувьтай байсан өсөлт ингэж буурахад юу нөлөөлсөн бэ. Хэрэглээний зээлийг хязгаарласнаас өөр ямар нөлөө байгаа вэ?

Мөнгөний бодлогын газар /МБГ/-ын захирал Б.Баярдаваа:

Зээлийн өсөлт нийт дүнгээрээ 4.5 хувьд хүрч, өсөлт нь эерэг байна. Энэ нь өмнөх жилүүдийнхтэй харьцуулбал, жилийн 12-13 хувийн өсөлтөөс буурсан дүн юм. Үүнд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Нэгдүгээрт, нийт зээлийн өсөлтөө хэрэглээ болон

бизнесийн гэж ангилж харвал хэрэглээний зээлийн өсөлт өмнөх онтой харьцуулахад 7.7 хувиар буурсан байна. Мөнгөн дүнгээр илэрхийлбэл 400 орчим тэрбум төгрөг гэсэн үг. Үүний нөгөө талд бизнесийн зээлийн өсөлт 11 хувьтай байна. Тэгэхээр хэрэглээний зээл рүү явж байсан санхүүгийн эх үүсвэр бизнесийн зээл рүү шилжсэн гэж харахаар байгаа юм. Түүнчлэн, зээлийн өсөлтийг дотор нь валютын төрлөөр авч үзвэл, зээлийн өсөлт нь төгрөг талдаа өсч, валют талдаа буурсан. Валютын зээлийн үлдэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 28 хувиар буурсан. Харин үүний нөгөө талд төгрөгийн зээлийн өсөлт 11 хувиар өссөн. Тэгэхээр доллараар бус төгрөгөөр эдийн засагт мөнгө нийлүүлэгдэж байна гэсэн үг. Энэ бол сайн үзүүлэлт.

Блүүмбэрг ТВ:

Санхүүгийн дансны ашиг нэмэгдэхэд компаниудын гаргасан бонд нөлөөлсөн гэж байна. Тэгэхээр ямар ямар бондууд, хэзээ орж ирсэн талаар мэдээлэл өгнө үү.

Судалгаа, статистикийн газар/ССГ/-ын захирал Б.Батдаваа:



Санхүүгийн дансны ашиг 2.3 тэрбум ам.долларын ашигтай гарсан. Үүнийг дотор нь задалбал, гадаадын шууд хөрөнгө оруулалт 2.1 тэрбум ам.доллар, багцын хөрөнгө оруулалт буюу аж ахуйн нэгжүүдийн гаргасан бонд 368 сая ам.доллар байна. Санхүүгийн данс ашигтай гарахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь дээрх 368 сая ам.долларын бонд юм. Үүнд гол нөлөөлсөн хүчин зүйл нь 2019 оны нэгдүгээр сард МИК ХК-ийн олон улсын зах зээл дээр гаргасан бондын эх үүсвэр орж ирсэнтэй холбоотой.

NTV:

ОУВС-ийн хөтөлбөрийн зургаа дахь шатны үнэлгээ одоо болтол хийгдээгүй байна. Гуравдугаар сард ажлын хэсэг ирнэ гэсэн. Яг ямар асуудлыг голчилж ярих вэ?

МБГ-ын захирал Б.Баярдаваа:

ОУВС-ийн техникийн хэрэгжилтийн ажлын хэсэг гуравдугаар сард ирнэ. Тэгэхээр энэхүү ажлын хэсэг нь эдийн засгийн төлөв байдал,

эдийн засгийн ирээдүйн хандлага дээр илүү төвлөрч ажиллана. Энэ нь цаашдаа ОУВС-тай яригдах асуудлуудын суурь болно.

Монгол ТВ:

Хятадын Ардын банкт байгуулсан своп хэлцлийн хугацаа энэ онд дуусна. Энэ асуудлыг хэрхэн шийдэх вэ, свопоо цааш нь үргэлжлүүлэх үү, эсвэл төлөх үү?

НУСЗГ-ын захирал А.Энхжин:


Своп хэлцлийн гэрээ 2020 оны долоодугаар сард дуусна. Үүнийг дахин 3 жилээр сунгах ажлыг Монголбанкнаас хийж байна. Хятадын Ардын банкны зүгээс ч бас уг асуудлаар урьдчилсан тохиролцоонд хүрсэн. Тэгэхээр энэ ажил хийгдэнэ. Ер нь цаашдаа 2020-2024 онд төлөгдөх ЗГ болон зарим нэг аж ахуйн нэгжүүдийн зээлийг дахин санхүүжүүлэх бүрэн боломжтой. Учир нь олон улсын зах зээл дээр одоо арилжаалагдаж байгаа ЗГ-ын бондын хүү 4-5 хувь буюу түүхэн доод түвшиндээ хүрээд байна. Энэ нь юуг илэрхийлж байна вэ гэхээр гадаадын хөрөнгө оруулагчдын Монгол Улсад итгэх итгэл өндөр байна. Засгийн газар өрөө дахин санхүүжүүлэх тохиолдолд үүнийг төсөвт дарамт багатай, урт хугацаатайгаар шийдэх боломжтой гэж харагдаж байгаа. Тэгэхээр ОУВС-ийн хөтөлбөр дуусаад, өр зээлийн асуудлаас болж, ханш өснө гэж хүлээх нь тийм ч үндэслэлтэй биш. Үүнийг валютын ханш болон нөөцөд дарамт учруулахгүйгээр шийдвэрлэх бүрэн боломжтой.



Монгол ТВ:

**Саарал жагсаалттай холбоотойгоор
Бээжинд болсон тайлангийн хуралд
Монголын төлөөлөгчид оролцоод ирсэн.
Үр дүн ямар байгаа вэ?**

ХЭЗГ-ын захирал Д.Аюуш:



Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн хамтарсан бүлгийн уулзалт 1 дүгээр сарын 16-23-ны хооронд Бээжин хотод зохион байгуулагдсан. Уг хуралд Сангийн сайд Ч.Хүрэлбаатараар ахлуулсан, хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын төлөөлөл бүхий баг оролцож, тайлангаа хамгаалсан. 2019 онд бид ФАТФ-аас үр дүнтэй байдлын хэрэгжилтийн 4 асуудал дээр 6 даалгавар авсан. Товчхондоо бол нийт зургаан даалгавараас гурвыг нь амжилттай биелүүлсэн гэсэн үр дүнтэй байна. Тухайлбал, нэгдүгээрт, шууд хэрэгжилт гурав буюу “Банкнаас бусад санхүүгийн салбар, нягтлан бодогч, хуульч, нотариатч, үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, алт, үнэт чулууны худалдаа эрхлэгчдийн эрсдэлийг үнэлэх, хяналт шалгалт хийх, зөрчил гаргасан этгээдэд авах арга хэмжээний үйл ажиллагаа хангалтгүй байна” гэсэн дүгнэлт өгөөд, үүн дээр хоёр даалгавар өгсөн. Энэхүү хоёр даалгаврын нэгийг нь хангалттай биелүүлсэн гэсэн үнэлгээ авсан. Хоёрдугаарт, шууд хэрэгжилт долоо нь мөнгө угаахтай холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаа 2017 оноос хойш нэмэгдсэн боловч, гэмт хэргийн эрсдэлийн түвшин, шүүхээр шийдсэн хэргийн тоо хангалтгүй байна” гэж дүгнэгдсэн. Үүн дээр ямар нэгэн ахиц гараагүй байна гэсэн үнэлгээтэй байна. Шууд хэрэгжилт 8 дээр нэг даалгавар авсан. Хилээр бэлэн мөнгийг мэдүүлэхгүй буюу худлаа мэдүүлж гаргахтай холбоотой зөрчилд авах арга хэмжээг сайжруулах шаардлагатай гэж үзэж байсан. Үүн дээр хангалттай биелүүлж, ахисан гэх үнэлгээг авсан. Мөн шууд хэрэгжилт 11 буюу Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой дутагдал байна. Мөн хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай гэж үзээд, хоёр даалгавар өгсөн байдаг. Үүний нэг

даалгаварыг биелүүлсэн байна гэж үзсэн. Энэ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг асуудлаар урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хийсэн байна гэж дүгнэсэн.

Zaluu.com:

Хэрэглээний зээлийг хязгаарласантай холбоотойгоор иргэдийн зээлийн эрэлт ББСБ руу шилжих асуудал бий. Монголбанк, СЗХ-той хамтраад ББСБ-уудад өр, орлогын харьцааны үзүүлэлт тогтоох талаар ярьж байсан. Энэ асуудал ямар шатандаа явж байгаа вэ?

МБГ-ын захирал Б.Баярдаваа:



Банк бус санхүүгийн салбар дахь зээлийн өсөлт хувиар нь харвал нэлээд өндөр байна. Гэхдээ яг нийт дүнгээр нь харвал 500-аад тэрбум төгрөгийн зээлийн өсөлт юм. Энэ нь хэрэглээний зээлтэй холбоотойгоор зээл шилжсэн гэхээсээ илүүтэй, ББСБ-ын үйл ажиллагаа их хялбар, түргэн шуурхай болж, финтекийн элементүүд орж ирсэн зэрэг нь нөлөөлж байна. Гэхдээ хэрэглээний зээлийг ББСБ-ын өндөр хүүтэй зээлээр санхүүжүүлсээр байх эрсдэл байгаа учраас арилжааны банкуудад хэрэгжүүлж буй макро зохистой бодлогын зохицуулалтыг ББСБ дээр давхар хэрэгжүүлэх ёстой. Ийм хэлэлцээрийг СЗХ-той өнгөрсөн оны 7, 8 дугаар сард хийж, зөвшилцөлд хүрсэн. Мөн үүнтэй холбоотойгоор хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг тооцох аргачлал, холбогдох судалгаа, материалуудыг СЗХ-нд хүргүүлсэн. Тэгэхээр энэ үйл ажиллагаа ямар шатандаа явж байна вэ гэдгийг СЗХ-оос тодруулах хэрэгтэй.

Livetv.mn:

Тэтгэврийн зээлийг тэглэхтэй холбоотойгоор олголтыг түр зогсоогоод байсан. Гэхдээ хоёрдугаар сараас тэтгэврийн зээлийг олгож эхэлнэ гэж байна. Энэ талаар мэдээлэл өгнө үү.

НУСЗГ-ын захирал А.Энхжин:

Тэтгэврийн зээлийг тэглэх хуульд “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийг 6 сараас ихгүй

хугацаагаар, жилд нэг удаа олгож болно” гэсэн заалт орсон. Гэхдээ үүнийг яаж хэрэгжүүлэх талаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, арилжааны банкуудтай хамтран ажиллах байх. Тиймээс тодорхой тайлбарыг одоогоор өгөх боломжгүй байна.

Livetv.mn:

Ам.доллар болон юанийн ханш он гарснаас хойш чангарсаар байна.

Монголбанк ханшийн өсөлтийн асуудлыг хэрхэн харж, дүгнэж байна вэ?

НУСЗГ-ын захирал А.Энхжин:

Төгрөгийн ханш он гарснаас хойш ам.долларын эсрэг 0.6 хувь, юанийн эсрэг 1.0 хувиар сулраад байна. Юанийн хувьд АНУ болон БНХАУ хооронд үүсээд байсан худалдааны маргаан ерөнхийдөө намжаад, нэгдүгээр шатны яриа хэлэлцээр хийгдсэн. Худалдааны маргаанаас шалтгаалаад, юанийн ханш ам.долларын эсрэг нэгдүгээр сарыг хүртэл 1.6 орчим хувиар чангараад байсан нь манай дотоодын төгрөг, юанийн ханшид шууд нөлөөлж, юанийн ханш чангарах нөлөө үзүүлсэн. Ам.долларын хувьд 0.6 хувиар төгрөгийн эсрэг чангарсан. Гэхдээ Монголбанк цаашдаа ханш тогтвортой байна гэж харж байгаа. Үүнд нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйл байна. Нэгдүгээрт, ханшид сөрөг нөлөө үзүүлж байсан гадаад, дотоод хүчин зүйлс манайд илүү таатай нөхцөл байдал руу шилжсэн. Гадаад хүчин зүйлсийн тухайд, худалдааны маргаан намжиж, дэлхийн эдийн засаг илүү сэргэх төлөв рүү орж байна гэдэг мэдээллийг олон улсын байгууллагуудаас өгч байна. АНУ-ын төв банкнаас бодлогын хүүгээ өнгөрсөн оны туршид 3 удаа буулгасан. Дунд, урт хугацаандаа хүү нам түвшинд байна гэсэн төсөөллийг олон улсын байгууллагуудаас өгч байгаа нь манай улсад эерэгээр нөлөөлнө. Дотоод эдийн засгийн хувьд өсөлт өндөр түвшинд хадгалагдаж байгаа нь үргэлжилнэ гэж төсөөлж байна. Гадаад валютын нөөц 4.3 тэрбум ам.долларт хүрч өссөн.

Төлбөрийн тэнцэл 450 орчим сая ам.долларын ашигтай гарсан. Худалдааны эргэлт түүхэн дээд хэмжээндээ хүрч, худалдааны ашиг 1.4 тэрбум ам.доллар болсон байна. Тэгэхээр дотоод, гадаад эдийн засгийн нөхцөл байдлаа

харвал ханш тогтвортой байх боломжтой. Хэрвээ ханшинд түр зуурын шинжтэй савлагаа үүсвэл Монголбанкны зүгээс тогтворжуулах бүрэн нөөц, бололцоо бий. Үүнийгээ төв банк ашиглана.

МҮОНТ:

Монголбанк 2020 оны нэгдүгээр сарын 1-нээс ипотекийн хөтөлбөрөөс гарна гэж байсан. Цаашдаа ипотекийн хөтөлбөр хэрхэн хэрэгжих вэ, Монголбанк үүнд огт оролцохгүйгээр явна гэсэн үг үү?

НУСЗГ-ын захирал А.Энхжин:


ОУВС-гийн хөтөлбөр болон Монголбанк, Сангийн яамны тохирсны дагуу Монголбанк энэ оны нэгдүгээр сарын 1-нээс ипотекийн хөтөлбөрөөс гарч байгаа. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд энэ хөтөлбөрийн хүрээнд ямар ажил хийгдсэнийг товчхон дүгнэж хэлье. 2018 онд Монголбанк, ЗГ-ын эх үүсвэрээс 316 тэрбум төгрөгийг банкуудад олгосон. 2019 онд ЗГ, Монголбанк, арилжааны банкны эх үүсвэрийг оролцуулснаар санхүүжилтийн хэмжээ 80 орчим хувиар нэмэгдсэн. Тэгэхээр 2019 онд нийтдээ 563 тэрбум төгрөгийн эх үүсвэр олгосон байна. 2020 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлд “Ипотекийн санхүүжилтийн тогтолцоог тогтвортой үргэлжлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Монголбанк, ЗГ, СЗХ-ноос хамтарч батална” гэсэн зээлт орсон. Монголбанкны зүгээс ипотекийн санхүүжилтийг илүү оновчтой болгох, зардлыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар ЗГ, СЗХ-той хамтран ажиллаж, зохицуулалтын шинжтэй арга хэмжээнүүдээ цааш үргэлжлүүлнэ.

СТАТИСТИК МЭДЭЭ


(2019 оны 12 дугаар сар)

1. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц




Зураг 1.2 Мөнгөний нийлүүлэлтийн байршуулалт



- **M2** мөнгөний жилийн өсөлт **7.0** хувьд хүрч **20.8** их наяд төгрөгт хүрэв. M2 мөнгөний жилийн өсөлтийн **4.9** нэгж хувийг төгрөгийн хадгаламж, **2.4** нэгж хувийг гадаад валютын хадгаламж, **0.3** нэгж хувийг гадаад валютын харилцах, **-0.4** нэгж хувийг төгрөгийн харилцах бүрдүүлсэн байна.
- **M2** мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн **17.9** их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн **3.0** их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна.

2. ЗЭЭЛ

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор



Зураг 2.2. Зээл, зээлийн чанар




- Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс **5.0** хувиар өсч **17.9** их наяд төгрөгт,
- Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл **4.0** хувиар өсч **9.3** их наяд, хувийн байгууллагынх **7.0** хувиар өсч **8.5** их наяд төгрөгт тус тус хүрчээ.
- Чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх сараас **92.8** тэрбум төгрөгөөр буурч, нийт зээлд эзлэх хэмжээ **10.1** хувь болжээ.

ЭЭЛЛИЙН ТОЙМ

2. ЗЭЭЛ /ҮРГЭЛЖЛЭЛ/

Зураг 2.3. Нийт зээл, гадаад валютын эзлэх хувь




Зураг 2.4. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар




- Нийт зээлийн **11.0** хувийг, иргэдийн зээлийн **1.2** хувийг, хувийн байгууллагын зээлийн **21.4** хувийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Зураг 3.1. Тайлант сард олгосон ипотекийн зээл




Зураг 3.2. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү




- Тайлант сард банкууд **1365** зээлдэгчид **111.9** тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос **56.3** хувь нь хөтөлбөрийн, **43.7** хувь нь банкуудын өөрийн зээл үүсвэрээр олгосон зээл байв
- Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сараас **1.1** нэгж хувиар буурчээ.

4. ХҮҮ

Зураг 4.1. 12 дугаар сард шинээр татсан хадгаламжийн хүү




Зураг 4.2. 12 дугаар сард шинээр олгосон зээл, хүү



- Иргэдээс татсан Ү-ийн хадгаламжийн ЖДХ **11.3** хувь, хувийн байгууллагаас татсан Ү-ийн хадгаламжийн ЖДХ **9.6** хувь байна.
- Иргэдэд шинээр олгосон Ү-ийн зээлийн ЖДХ **18.5** хувь, хувийн байгууллагад олгосон Ү-ийн зээлийн ЖДХ **15.7** хувь байна.

5.1 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН СТАТИСТИК, 2019 ОНЫ ЭХНИЙ 12 САР



МӨНГӨН ТОНОГТОЙ ХОС БИШГҮҮР

XIX - XX зуун
Хүрээ хийц
Мод, мөнгө, хөөмөл

1. Бишгүүр: өргөн 17 см, өндөр 72 см, жин: 1122.0 гр
2. Бишгүүр: өргөн 17 см, өндөр 72 см, жин: 1133.0 гр

1985 онд Төв аймгийн Баянцагаан сумаас Эрдэнэсийн сангийн фондыг нэмэгдүүлэх зорилгоор худалдан авчээ.


Эл хөгжмийн зэмсэг, хүж хоёрыг Жоу Адиша Жагарын орноос Түвэдэд дэлгэрүүлсэн гэх домогтой. Бишгүүрийн аялгуу нь галандага ариун шувууны дууг санагдуулах ёстой хэмээн бэлгэдэн урладаг байна. Уг бишгүүрийн их биеийг хатуу модоор, цар үлээгүүрийг нь мөнгөөр хийж долоон бүслүүр гаргасан бөгөөд луу болон чандмань эрдэнийг хөөмөлдөн чимэглэжээ.



Монголбанкны Эрдэнэсийн сангаас

КОРОНАВИРУС

ЭДИЙН ЗАСАГ БА АРД ИРГЭДИЙН СЭТГЭЛЗҮЙД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?



Б.Түмэнцэнгэл

/Монголбанкны МБГ-ын ЭЗШБХ-ийн
захирал/

КОРОНА ВИРУСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨ НЬ ЯМАР БАЙХ ВЭ?

“Одоохондоо хэлэхэд эрт” гэдэг нь энэ чухал асуултын хамгийн оновчтой хариулт юм. Богино хугацаанд олон улсын зах зээл дээр зарим савлагаа, үнийн хэлбэлзэл ажиглагдаж байгаа бол дунд урт хугацаанд вирус тархалт, түүнд улс орнуудын үзүүлэх хариу үйлдлээс их зүйл шалтгаалах болно.

Богино хугацааг авч үзвэл, өвчний шууд үр дүн нь зах зээл дээрх айдас, савлагаа хэлбэрээр илэрч буй. Тухайлбал, Цагаан сарын дараах 10 гаруй хоног үргэлжилсэн амралтын дараа Хятадын санхүүгийн зах зээл нээгдэхэд хувьцаа, юанийн ханш болон түүхий эдийн уналт бий болов. Мөн зарим агаарын тээврийн компаниуд Хятад руу хийх нислэгээ цуцлах, улс орнууд иргэдээ Хятад руу зорчихгүй байхыг анхааруулах зэрэг арга хэмжээг авч буй. Мөн Хятад өөрөө ч шинэ вирус идэвхтэй тархаж байгаа муж, хотуудад хорио цээр тогтоох арга хэмжээг авсан. Энэ нь аялал жуулчлал, тээвэр, нийтийн хоол, үзвэр үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаанд шууд мэдрэгдэж буй. Гэхдээ нөгөө талаар интернет худалдаа өсөх, эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэх гэх мэт өөр салбаруудын үйл ажиллагааны идэвхжилд нөлөөтэй. Харин Цагаан сарын амралтын үеэр үйл ажиллагаа нь зогсонги байсан салбаруудад төдийлөн нөлөө нь мэдрэгдэхгүй болов уу. Иймд вирус нөлөө Хятадын, болон бусад орнуудын эдийн засагт хэр их нөлөөтэй байв гэдгийг статистик тоо нэгтгэгдсэн хойно л хэлэх боломжтой юм. Харин илүү дунд болон урт хугацааны үр дүнг урьдчилж таамаглах нь хэцүү юм. Учир

нь вирус тархалт хэр өргөн цар хүрээтэй байх вэ, түүнд хариу үйлдэл үзүүлж буй арга хэмжээнүүд хэр үр дүнтэй байх вэ гэдгээс их зүйл шалтгаална. Нэг талд өвчлөгсдийн тоо хурдтай нэмэгдэж буй ч, нөгөө талд шинжлэх ухаан өндөр хөгжсөн өнөө үед вирусыг тусад нь ялгаж аваад судалж буй (Япон), дархлаа дэмжих үр дүнтэй эмчилгээг олсон (Тайланд) зэрэг эерэг мэдээ ч байна. Тэгэхээр цаг хугацаа л харуулах ийм зүйл дээр тэвчээртэй, тайван байх нь чухал юм.

СӨРӨГ МЭДЭЭНД ИЛҮҮ СОНОР БАЙДАЛ

Хүн цагаан цаасан дээрх ганцхан хар цэгт анхаарлаа хандуулдаг шиг хар бараан мэдээ, муу зүйлст илүү төвлөрдөг. Учир нь аливаа аюулд сонор сэрэмжтэй байх нь хүний натур, амьд үлдэх инстинкт юм. Медиа ч үүнийг сайн ашигладаг бөгөөд, олон хандалт авч сайн зарагдах мэдээнүүд ихэвчлэн “муу мэдээ” байдаг (мэдээний гарчгийг судлаад үзэхэд 80 хувь нь сөрөг байна гэсэн барууны судалгаанууд ч бий). Сошиал медиа хөгжсөн өнөө үед энэ процесс улам ч хүчтэй болж, вирус тархалт мэдээ вирус тархалтаас хэд дахин хурдаар түгэж байгааг харж болно. Гэхдээ бодит мэдээлэл байлаа ч анхаарал болгоомж гэхээсээ шаардлагагүй айдас, паник үүсгэж байвал тийм ч сайн хэрэг биш. Газар хүчтэй хөдлөх үед тэвдэж гүйж яваад гэмтэх нь олон тохиолддогтой адил үүссэн паник нь тухайн аюулаасаа илүү эрсдэлтэй байж ч болдог. Иймд эрсдэлээс сэргийлэх зүйлсээ сайн хийчихээд, тайван байх нь шаардлагагүй рискээс сэргийлнэ. Мэдээж өдөр бүр өвчлөгсдийн тоо хурдтай нэмэгдэх, олон хүн нас барж буй талаарх бараан мэдээг хараад тайван суух хэцүү. Корона вирус тархалтын оргил үе хүртэл цаашид ч нэг хэсэгтээ эдгээр нь өсөх нь тодорхой статистик

юм. Харин эмоцио түр дараад тархиараа бодит эрсдэлийг бодоод үзвэл арай өөр өнцгөөс харах боломжтой. Коронавирусын хувьд хурдтай тархаж буй ч үхэлд хүргэх магадлал нь одоогоор 2 хувь орчим гэгдэж байна (2 сарын 3-ны байдлаар 17000 тохиолдлоос нас барсан нь 360). Үүнтэй харьцуулахад 2003 онд дэлгэрсэн SARS-ын хувьд энэ үзүүлэлт 10 хувь байв. Түүнчлэн, 2019-2020 оны өвлийн ид хүйтний улирлаар Америкт 15 сая хүн ханиад хүрч, 8000 гаруй хүн нас барсан гэдэг статистик бий. Монголд гэхэд уушгины хатгалгаар нас барсан хүний тоо 400 давсныг мэдээлсэн. Иймэрхүү харьцуулалт, бодит тоон үзүүлэлтүүд дан айдас эмоцид автах бус, илүү логиктой сэтгэхэд тусална.

СҮРГИЙН ЗАН АВИР

Хүн нийгмийн амьтан учраас хүссэн хүсээгүй бие биенээ дууриадаг зантай нь заримдаа сөрөг үр дагаварт хүргэх тохиолдол бий. Томчуудыг дуурайж буй балчир хүүхэд, найз нөхөдтэйгээ дарвиж буй өсвөр насныхан, хувцасны мода дагаж буй залуу бүсгүй гээд энэ нь түгээмэл ажиглагддаг зүйл. Хувьцаа уралдаж зарж буй хөрөнгө оруулагч үүний нэг жишээ байж болно. Дэлгүүрт талх гурил уралдаж авч буй хэрэглэгчид ч бас нэг жишээ юм. Гэхдээ хувь хүний дор бүрээ өөртөө ашигтай гэж бодоод гаргасан шийдвэр нийлбэр дүнгээрээ нийгэмдээ тусгүй, өөрсдөд нь эргээд хохиролтой үр дүнд хүргэж болдог. Зах зээл дээр энэ нь нийлүүлэлтийн илүүдэл эсвэл хомсолд хүргэж үнийн хөөргөдөл эсвэл уналтыг үүсгэж, олон хүнийг хохироох тохиолдлууд ч бий. Жишээ нь дэлгүүрийн лангуу хоосорч талхны үнэ өсөхөд хүрэх, эсвэл хувьцааны үнэ огцом унаж хөрөнгө оруулагчид мөнгөө алдаж болно. Эдгээр шаардлагагүй эрсдэлээс зайлсхийх нэг арга нь ердөө л эмх цэгцтэй, тайван байдал юм. Аливаа эрсдэл, байгалийн аюулт үзэгдлийн үед нийгэм паниктаж, эмх замбараагаа алдах нь тухайн гамшгаасаа илүү сөрөг үр дагавар авчирсан жишээ хүн төрөлхтний түүхэнд цөөнгүй бий.

КОРОНАВИРУСЫН ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ



Корона төрлийн вирус 2019 оны 12 дугаар сард анх илэрсэн бөгөөд Хятадын Ухань хотын далай болон зэрлэг амьтдын худалдааны захаас гарсан гэж үзэж байна. Ямар амьтнаас халдварласан нь тодорхой бус байгаа ч могой, эсвэл сарьсан багваахай гэж шинжээчид таамаглажээ. Вирус нь амьтнаас хүнд халдахаас гадна хүнээс хүнд халдаж байгаа нь тодорхой болоод байна. Ингэхдээ агаар дуслын замаар вирус халдахын зэрэгцээ нүдэнд вирус орсон тохиолдолд мөн халдвар авч байгаа юм.

Өвчлөлийн хүндрэл, тархалт сүүлийн 7 хоногт эрс нэмэгдсэнээс Хятадын хөрөнгийн зах зээлийн индексүүд болон газрын тосны үнэ буурч эхэлсэн бол алтны ханш өсч, зэсийн ханш унаад байна.


Газрын тосны үнэ: Иран болон АНУ-ын харилцаа зөөлөрсөний дараа WTI төрлийн газрын тосны ханш 58-60 ам.долларт хүрээд байсан бол коронавирусын тархалтаас үүдэн 53 ам.долларт хүрч буураад байна.



Алтны ханш: АНУ болон Ираны харилцаанаас үүдэн 1,610 хүрээд байсан алтны ханш эргэн буурч, 1,540-1,550 ам.долларын хооронд хэлбэлзэж байсан бол 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар 1,583 ам.долларт хүрчээ. Ийнхүү өсч буй шалтгаан нь коронавирусаар дамжин дэлхийн эдийн засаг, тэр дундаа Хятадын эдийн засагт эрсдэл нэмэгдэж буйтай холбоотой юм. Мөн 2020 оны 1 дүгээр сард алтны бирж дээрх арилжаа (gold exchange traded funds)-ны хэмжээ өнгөрсөн жилийн дунджаас 3 дахин өндөр байна.



Зураг 1. Алтаар баталгаажсан үнэт цаасны хэмжээ өсч байна (Сая трои унци)



Зураг 2. Алтны үнэ цаашид өсөх хандлагатай байна



Зэсийн ханш: АНУ болон Хятадын гадаад худалдааны "дайн"-аас үүдэн эдийн засгийн өсөлт саарч эхлээд байсны дээр коронавирусын халдвараас үүдэн томоохон салбаруудын өсөлт саарах эрсдэлтэй болж байгаа нь зэсийн ханш буурах нөхцөл боллоо. Дэлхийн зэсийн нийт хэрэглээний 45 хувийг дангаараа бүрдүүлдэг Хятадын эдийн засгийн өсөлтийг 2020 онд 6 хувьд хүрнэ гэж таамаглаж байсан хэдий ч коронавирустэй холбоотойгоор уг таамаглалыг 5 хувь болон

түүнээс доош хэмжээнд хүрнэ гэсэн хүлээлт бий болоод байна. Коронавирусын нөлөөгөөр ээсийн үнэ 11 хувиар буурч, 1 тонн ээсийн үнэ 5,600 ам.долларт хүрчээ.

ХЯТАДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



Хятадын засгийн газраас вирусын тархалтыг зогсоох зорилгоор цагаан сарын баярын үеэр олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглох шийдвэр гаргахын зэрэгцээ 35 сая хүнийг хамарсан хорио цээрийн арга хэмжээ авав. Мөн олон нийт цуглардаг үзвэр үйлчилгээний газруудыг хаасан байна. Жишээлбэл, өдөрт 100,000 хүнд үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байсан Шанхайн Диснейлэнд хаалгаа барьсан байна. Мөн Хятад улсад нээлтээ хийх байсан кинонууд хойшилж байгаа нь дэлхийн кино үйлдвэрийн салбарын орлогыг үлэмж хэмжээгээр бууруулж байна. Үүнээс гадна олон тооны аялал жуулчлалын компаниуд үйл ажиллагаагаа зогсоож байгаа нь тус салбарын орлогод сөргөөр нөлөөлөх юм.


Ийнхүү Хятадын эдийн засагт багагүй хэмжээний мөнгөний эргэлт зогсож байгаа



нь хөрөнгийн зах унах үндсэн шалтгаан болж эхэллээ.

АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

АНУ болон Хятадын хооронд үүссэн худалдааны маргааныг шийдвэрлэх эхний шатны хэлэлцээр болно гэсэн мэдэгдэл гарснаар 2019 оны сүүл үеэс хувьцаануудын ханш өсч АНУ-ын хөрөнгийн зах зээл түүхэн дээд цэгтээ хүрээд байсан юм. Хэдий суурь хүчин зүйлсийн төлөв эерэг байгаа хэдий ч Хятадад гарсан шинэ төрлийн коронавирусын асуудал зах зээлд гэнэтийн уналтыг үүсгээд байна. Үүнээс үүдэн дэлхийн хөрөнгийн зах зээлд түр хугацааны завсарын уналт явагдах магадлал өндөр байна. Мөн АНУ-д асуудал улам хүндэрвэл хөрөнгийн зах зээлд томоохон завсарын уналт тохиох нь тодорхой юм. S&P 500 индекс 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар 1.8 хувиар буурсан бол Dow Jones индекс 2-оос дээш хувиар буураад байгаа бөгөөд коронавирусын тархалт нь хямралын дохиог өгч байна.



Зураг 3. 10 болон 3 жилийн хугацаатай АНУ-ын ЗГҮЦ-ны өгөөжийн зөрүү (суурь нэгжээр)

НЭГДҮГЭЭР САРД 3,558 КГ ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2020 оны 1 дүгээр сард 3,558 кг үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үед 597 кг үнэт металл худалдан авснаас 2,960 кг-аар их буюу 5 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүнд, (1) алтны үнэ 1 дүгээр сард өндөр түвшинд байсан, (2) цагаан өнгө худалдан авч эхэлсэн нь нөлөөллөө.

2020 оны 1 дүгээр сард 3,558 кг үнэт металл худалдсан авсан ба үүнээс 1,747 кг


нь цагаан мөнгө, 1,810 кг нь алт байсан. Монголбанк 2020 оны 1 дүгээр сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 61 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 72 кг үнэт металлыг худалдаж авсан байна. 2020 оны 1 дүгээр сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 137,211.81 төгрөг байлаа.



Дүрслэл 1. 2018-2019 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын сарын мэдээ (кг)



Дүрслэл 2. 1990-2019 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (тонн)



Дүрслэл 3. 2020 оны 1 дүгээр сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)

САНХҮҮГИЙН ЗАЛИЛАНГААС СЭРГИЙЛЭХИЙН ТУЛД ХАРИЛЦАГЧИД ЮУНД АНХААРАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Залилан луйврын гэмт хэрэг цахим хөгжлийг дагаад улам бүр төгөлдөршиж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт жил ирэх бүр нэмэгдэх хандлагатай болжээ. Цагдаагийн ерөнхий газраас өгсөн мэдээллээр 2016 онд 2 тэрбум орчим төгрөг, 2017 онд 6.4 тэрбум, 2018 онд 9.9 тэрбум, 2019 он гарсаар энэ тоо 13 тэрбум төгрөгт хүрч өсчээ. Үүний гол шалтгаан нь иргэд олон нийт залилагчдад үргэлж боломжийг олгож байдагтай холбоотой юм. Иймд тус байгууллагаас санаачлан Монголбанк, Монголын банкуудын холбоотой хамтран “Ятгах тусам нягтал” аяныг нийгэмд өрнүүлж, сонор сэрэмжтэй байхыг зөвлөн эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалахад туслах мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Монголбанк энэхүү аяныг хамтран хэрэгжүүлэгчийн хувьд уншигч таны анхаарлыг ч мөн энэ сэдэвт хандуулж байна.



Худалдаа хөгжлийн банкны
Гүйцэтгэх захирлын орлогч
Б.Баярмаа:

Гар утас, таблет, компьютер ашиглан хаа байгаа газраасаа төлбөр тооцоог шуурхай, хялбар хийх боломжтой болсон энэ цаг үед гэмт этгээдүүд таны хайхрамжгүй, бусдад мэдээллээ нээлттэй хуваалцдаг байдлыг ашиглан санхүүгийн луйврын золиос болгохоор гэтэж байна. Тийм учраас дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлээрэй. Үүнд, олны танил, эсвэл таны хамгийн сайн мэддэг танил хүмүүс чинь фэйсбүүк чатаар дамжуулан таниас мөнгө зээлэх, мөнгө шилжүүлэхийг гуйвал заавал тэр хүмүүс рүүгээ утасдаж, давхар нягтлаарай. Хоёрдугаарт, банкны данс, и-мэйл хаяг, цахим гүйлгээний нэвтрэх нэр, нууц үгүүдээ бусдад дамжуулахгүй байхад анхаараарай. Тантай олон жил харилцаж байгаа харилцагчийн тань дансны дугаар өөрчлөгдсөн, эсвэл и-мэйл болон утсаар харилцдаг хүмүүсийн мэдээлэл өөрчлөгдвөл заавал тухайн хүмүүстэйгээ утсаар давхар холбогдож, лавлаарай. Гуравдугаарт АТМ дээрээс бусдын мөнгийг дансаараа дамжуулан битгий авч өгөөрэй. Дансаа бусдад бүү ашиглуулаарай.



Голомт банкны гүйцэтгэх
захирал Норихико Като:

Санхүүгийн залилан, луйвраас харилцагчдаа хамгаалж, харилцагчдынхаа мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь бидний үйл ажиллагааны чухал хэсэг. Тиймээс ч банкууд харилцагчдынхаа хувийн мэдээллийг хамгаалахын тулд ихээхэн хүчин зүтгэл гарган ажиллаж байна. Технологийн хөгжлийг дагаад дижитал банк буюу интернэт банк нь хэрэглэхэд хялбар байдлаар харилцагчдын байнгын хэрэглээ болж, үүний хэрээр цахим аюулгүй байдалд ч мөн илүү их анхаарал хандуулах хэрэгтэй болж байна. Тиймээс харилцагч таныг сэжиг бүхий хүсэлт, зурвас цахимаар хүлээж авсан тохиолдолд хэдхэн хором тухайн мэдээллийг нягтлахад зориулж, санхүүгийн залилангаас өөрийгөө хамгаалахыг уриалж байна.



Кредит банкны Гүйцэтгэх
захирал Г.Болорсүх:

Дэлхийн техник, технологийн хөгжлийг дагаад банкны бүх төрлийн үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран авдаг болсон энэ цаг үед харилцагч та өөрийн санхүүгийн нууцлалаа хамгаалах хариуцлагатай тулаад байна. Тиймээс та интернэт банк болон гар утасны аппликэйшн ашиглан санхүүгийн гүйлгээ хийхдээ нууц үгээ бусдад алдахгүй байх, нууц үгээ наймаас дээш тэмдэгтээр бүрдүүлэх, гүйлгээ хийж дууссаны дараа программаас бүрэн гарах, олон нийтийн газар болон үнэгүй wifi ашигласан тохиолдолд хувийн мэдээллийг бусдад дамжуулахгүй байх хэрэгтэйг анхаараарай. Санхүүгийн луйвраас сэргийлцгээ.



Төрийн банкны гүйцэтгэх
захирал Г.Дөлгөөн:

Мэдээллийн технологи, финтекийн хөгжлийг дагасан цахим шилжилтийн үр дүнд харилцагч банкны үйлчилгээг илүү хялбар, шуурхай авах боломж бүрдэхийн хэрээр харилцагч танд өөрийн санхүүгийн нууцлалаа хамгаалах өндөр хариуцлага ирж байна. Иймд харилцагч та цахим орчинд өөрийгөө хамгаалахын тулд дараах зөвлөмжийг дагаарай. Үүнд, харилцагч та хувийн мэдээллээ бусдад нээлттэй хуваалцахгүй байх, цахим харилцааны сувгаар хэн нэгэн нь таниас мөнгө зээлэхийг хүсвэл заавал утсаар холбогдон, баталгаажуулах хэрэгтэй. Таны утсанд мессежээр ирэх цахим код, нэг удаагийн нууц үгийг бусдад дамжуулахгүй байх, гадаадад явахдаа өндөр нууцлал бүхий олон улсын EMV чиптэй карт авч явахыг зөвлөж байна. Мөн Төрийн банкны хувьд цахим банкны аппликэйшн нь давхар нууцлал бүхий гурван асуулт, хариулттай. Иймээс уг асуултаа бусад хүн хялбар хариулж чадахааргүй бүртгүүлж чадвал цахим эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой.

А.ЭНХЖИН: ТӨГРӨГИЙН ХАНШИЙН СУЛРАЛТАД НӨЛӨӨЛЖ БАЙСАН ГАДААД, ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛС ЭЕРЭГ ЧИГЛЭЛД ӨӨРЧЛӨГДСӨН



Гадаад валютын ханш болон валютын зах зээлд үүсээд буй нөхцөл байдлын талаар Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжинтэй ярилцлаа.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулрахад голлон нөлөөлж буй хүчин зүйлийг юуны өмнө тайлбарлана уу?

Урт хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулраад буйг энгийнээр тайлбарлавал, Монголчууд бидний гадаад валютаар олж байгаа орлого, гадаад валютын зарлагаасаа өндөр байгаа нь ийнхүү төгрөгийн ханш сулрах үндсэн шалтгаан болж байна. Өнгөрсөн хугацаанд үүссэн орлого, зарлагын зөрүүгээ бид гадаад зах зээлээс зээлэх замаар санхүүжүүлсэн байдаг. Үүнээс шалтгаалан Монгол Улсын гадаад өр 30 гаруй тэрбум ам.долларт хүрээд байна.

Иймд Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, аялал жуулчлал, мэдээлэл технологи гэх мэт үйлчилгээг гадны зах

зээлд худалдан гадаад валютын орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлж байж бид энэ асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжтой.

Харин харьцангуй богино хугацаанд буюу сүүлийн 1-2 жилийн хугацаанд дээр дурдсан суурь асуудлаас гадна дотоод, гадаад зах зээлд юу болсныг харвал 2018 онд Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 4 удаа буюу нийтдээ 100 суурь нэгжээр өсгөсөн бөгөөд мөнгөний бодлогын нэг онцлог нь шийдвэр гарснаасаа хойш уг шийдвэр 2 жил магадгүй зарим тохиолдолд түүнээс ч удаан зах зээлд нөлөөлсөөр байдаг. Мөн 2018, 2019 оны 2 дугаар хагасд дэлхийн зах зээл дэх зэс, нүүрсний үнэ буурсан, АНУ, БНХАУ-ын худалдааны маргаанаас үүдэлтэй тодорхой бус байдал нь гадаад зах зээл талаас төгрөгийн ханш сулрахад нөлөөлж байв.

Дотоод эдийн засаг талаас эдийн засгийн

идэвхжил нэмэгдэж буйтай холбоотой зээл олголт болон импортын хэмжээ өссөн. 2018, 2019 оны 4 дүгээр улиралд хилийн боомтуудын үйл ажиллагаа доголдож, нүүрсний экспорт саатсан, Монгол Улс ФАТФ-ын саарал жагсаалтад орсноос валютын зах зээлд сөрөг хүлээлт үүссэн зэрэг нь төгрөгийн ханш сулрахад голлон нөлөөлөв.

Төв банкнаас төгрөгийн ханш сулрах үзэгдэл нь бодлогын хувьд нийцтэй эсэх дээр ямар байр суурийг илэрхийлэх вэ?

Юуны өмнө төгрөгийн ханш ямар хугацаанд сулрах гэж байгаад анхаарал хандуулах нь зүйтэй. Монгол Улс жижиг бөгөөд нээлттэй эдийн засагтай. Үүнийгээ дагаад төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь төв банкны үндсэн зорилт болох инфляци болон санхүүгийн тогтвортой байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. Монголбанкны зүгээс богино хугацаанд төгрөгийн ханшид эрэлт, нийлүүлэлтийн зөрүүнээс үүдэлтэй, түр зуурын шинжтэй огцом сулрах эрсдэл үүсвэл үүнийг зөөлрүүлэх зорилгоор валютын захад тухай бүр оролцон ажилладаг. Эдгээр бодлогын шийдвэр нь төв банкны гол зорилт болох инфляцийг зорилтот түвшинд хадгалах, эдийн засаг, санхүүгийн системийн тогтвортой байдлыг алдагдуулахгүй, “аюулгүй” байлгахад чиглэж гардаг. Харин урт хугацаандаа төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь түүнд нөлөөлөгч гадаад болон дотоод эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэйгээр тогтдог.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай, өөрөөр хэлбэл, ам.доллар орж ирэх урсгал эерэг үзүүлэлттэй байхад яагаад төгрөгийн ханш суларч байгааг тайлбарлана уу?

Гаалийн Ерөнхий газраас зарлаж буй гадаад худалдааны статистик нь Монгол Улсын хилээр орж, гарч буй барааны статистик тул уг статистик нь шууд гадаад валютын орлого зарлагыг илэрхийлдэггүй. Жишээлбэл, нефть экспортлогчид бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу экспортлосон бүтээгдэхүүний үнийн дүнгээс тодорхой хэсгийг хөрөнгө

оруулагч талд төлдөг. Харин нүүрсний экспортын хувьд улсын хил хүртэл нүүрсийг тээвэрлэж буй гадны компаниуд тээврийн үйлчилгээний хөлс нүүрсний экспортын үнэд шингэсэн байдаг. Үүнээс гадна төрөл бүрийн үйлчилгээний зардал, гадаад зээл, бондын үндсэн болон хүүгийн төлбөр гэх мэт гүйлгээ гаалийн статистикт тусдаггүй.

Харин Монголчуудын гадаад эдийн засагтай хийж буй бүх төрлийн гүйлгээг хамруулсан тайлан нь төлбөрийн тэнцлийн тайлан байдаг. Төлбөрийн тэнцлийн тайланд дээр дурдсан гаалийн статистик дахь гүйлгээнүүдийг тусад нь бүртгэдэг учир гадаад валютын орлого, зарлагын гүйлгээ нь төлбөрийн тэнцэл дэх урсгал дансны бүтцээс маш тодорхой харагддаг. Хэдийгээр гаалийн статистикаар гадаад худалдааны тэнцэл 2019 онд 1.5 тэрбум ам.доллартай тэнцүү байгаа ч Монгол Улсын урсгал данс эхний 11 сарын байдлаар эсрэгээрээ 1.4 тэрбум ам.долларын алдагдалтай байна. Урсгал дансны байнга өндөр хэмжээний алдагдалтай байдаг нь ийнхүү төгрөгийн ханш суларч байгаагийн үндсэн шалтгаан юм.

Монголбанк нэлээдгүй интервенц хийсэн байна. Энэ нь зах зээлд харин ч төгрөг суларсаар байх юм байна гэсэн сөрөг хүлээлтийг үүсгэх нөхцөлийг бүрдүүлээд байна гэсэн шүүмжлэлийг зарим эдийн засагч хэлж байна. Бодит нөхцөл байдлыг тайлбарлана уу?

Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний 90 орчим хувийг уул уурхайн салбар бүрдүүлдэг. Уг салбар нь цөөн тооны томоохон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаан дээр тогтож байна. Монгол Улс байнга урсгал дансны алдагдалтай байдаг тул гадаад валютын эрэлт зах зээлд өндөр байдаг. Үүнээс шалтгаалан валютын нийлүүлэлтийг бүрдүүлдэг цөөн тооны аж ахуйн нэгжийн орлого Монгол Улсад ороход онолын дагуу валютын ханш сулрах дарамт багасах учиртай. Гэтэл эсрэгээрээ уг валютыг үнээр өрсөлдүүлэн худалдаж байснаас үүдэлтэй төгрөгийн ханш сулрах явдал гардаг байсан.

Төрөөс 2019 онд мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн 1.2-д

“Эдийн засгийн дархлааг дэмжих, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж заасан байгаа. Ингэхдээ төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид огцом хэлбэлзэл үүсгэхгүй байх зарчмыг баримтална гэж заасан. Монголбанкны хувьд дотоодын зах зээлээс гадаад валют худалдан авах замаар гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэхэд одоогоор хүндрэлтэй байна. Иймд эхний ээлжинд бид Монгол улсын гадаад худалдааны төвлөрлөөс үүдэлтэйгээр ханшид үүсдэг байсан хэлбэлзлийг арилгах талаар Засгийн газартай хамтран ажилласан. Тодруулбал манай улсын гадаад валютын нийлүүлэлтийг бүрдүүлдэг аж ахуйн нэгжийн дунд төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж багагүй жин эзэлдэг. Иймд ядаж эдгээр аж ахуйн нэгжийн валютын орлогыг Монголбанк худалдан авч, үүнийгээ хэлбэлзэл үүсгэхгүйгээр захад нийлүүлэх нь зүйтэй гэж үзсэний дагуу тэдгээрээс гадаад валют худалдан авч байгаа юм. Өнгөрсөн онд бид зах зээлээс 2.3 тэрбум ам.долларыг худалдан авч, эргүүлээд 2.9 тэрбум ам.долларыг захад нийлүүлсэн байна. Тодруулбал, Монголбанк дээр дурдсан аж ахуйн нэгжүүдээс авсан валютаа захад нийлүүлж, нэмээд Монголбанкнаас 0.6 тэрбум ам.долларыг захад нийлүүлсэн.

Үүнээс гадна ГВАН хангалттай түвшинд хүрсэн байхад ам.доллар чангарч байгаа үзэгдэл нь Төв банк зах зээлээс доллар хамж эрэлтийг үүсгэж байна гэж ч харж байна шүү дээ.

Монголбанк цэвэр дүнгээр нь аваад үзвэл захаас гадаад валют татах бус харин ч нийлүүлсэн байгааг дээр дурдсан. Харин ГВАН өсөхөд Монголбанк иргэд, аж ахуйн нэгжээс алт худалдан авч түүнийгээ цэвэршүүлэх, банкуудын гадаад зах зээлээс татсан эх үүсвэрийг своп хэлцэл байгуулан худалдан авах, гадаад валютын нөөцийн өгөөжийг нэмэгдүүлэх гэх мэт арга хэмжээ голлон нөлөөлсөн.

Зарим эдийн засагчид ГВАН-ийг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх нь зүйтэй гэдэг бол эсрэгээрээ уг бодлогыг шүүмжлэх хэсэг бас байдаг. Үүнийг Монголбанк юу гэж үзэж байгаа вэ?

Монгол Улс ирэх 4 жилд 14 орчим тэрбум ам.доллартай тэнцэхүйц гадаад өр эргэн төлөгдөх хуваарьтай байгаа. Өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлаас үзвэл уг өр, төлбөрийн хугацааг сунгах зайлшгүй шаардлагатай байна. Ийнхүү гадаад өр төлбөрийг дахин санхүүжүүлэхэд Монгол Улсын эдийн засаг тогтвортой, гадаад валютын төлбөр гүйцэтгэх чадвар сайн байж чадсанаар дээрх өр, төлбөрийг бага хүүтэй, урт хугацаатайгаар дахин санхүүжүүлэх боломжтой. Монголбанкны хувьд 2020 оны 7 дугаар сард дуусах Хятадын Ардын Банктай байгуулсан своп хэлцлийн хугацааг сунгахаар ажиллаж байгаа бөгөөд уг хэлцлийг амжилттай сунгана гэдэгт итгэлтэй байна. Харин Засгийн газрын өрийн удирдлагын стратеги 2019 онд батлагдсан. Уг стратегид Засгийн газар томоохон дүнтэй гадаад өр, зээлүүдээ эдийн засагт дарамтгүйгээр дахин санхүүжүүлэхээр тусгасан байдаг. Монголбанк ч энэ чиглэлд Засгийн газартай хамтран ажиллаж, гадаад өрийг эдийн засагт дарамт багатайгаар дахин санхүүжүүлэхээр ажиллах болно.

Долларжилтийг бууруулахын тулд төв банкнаас ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

Долларжилтыг бууруулах чиглэлээр Монголбанкнаас гадаад валютын орлогогүй иргэд, аж ахуйн нэгжид гадаад валютаар зээл олгоход тооцогдох эрсдэлийн жинг 120% байсныг 150% болгон нэмэгдүүлэх, гадаад валютын заавал байлгах нөөцийн хэмжээг 12% байсныг 15% болгож өгсөх зэрэг макро зохистой бодлогын арга хэмжээ авсан. Мөн банкуудын гадаад валютын эх үүсвэрийг ханшийн эрсдэлгүйгээр төгрөгт хөрвүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төгрөгөөр зээл олгох боломжийг бүрдүүлэх үүднээс банкуудтай урт хугацаат своп хэлцэл байгуулж ажиллаж байна. Ингэснээр 2012-13 онд 30 гаруй хувьтай

байсан активын бодит долларжилт 2019 онд 12-13% болж буураад байна.

Ам.долларын ханшаас гадна манай улсын хамгийн их эрэлттэй, нийт гадаад худалдааны 60 –аад хувьд ашиглагддаг юань түүхэндээ өндөр дүнтэй чангарч байгаа нь ямар шалтгаантай вэ?

БНХАУ болон АНУ-ын хооронд үүссэн худалдааны маргаан намжиж, БНХАУ-ын эдийн засагтай холбоотой тодорхой бус байдал буурахын хэрээр юанийн олон улсын зах зээл дэх ханш чангарах хандлагатай болсон. Дотоод эдийн засаг талаас авч үзвэл ФАТФ-ын саарал жагсаалтад Монгол Улс орсонтой холбоотой зах зээлд үүссэн сөрөг хүлээлтээс үүдэлтэй төгрөгийн ханш сулрах үзэгдэл баяр ёслолын бэлтгэлээс үүдэлтэй импортын эрэлт нэмэгдсэн зэрэг хүчин зүйлс нь дотоодын зах зээлд юанийн ханш чангарахад нөлөөлж байна.

Цаашид төгрөгийн гадаад валюттай харьцах ханш ямар байх төлөвтэй байна вэ?

Өнгөрсөн хугацаанд төгрөгийн ханшийг сулруулахад нөлөөлж байсан гадаад болон дотоод эдийн засгийн хүчин зүйлс харьцангуй эерэг чиглэлд өөрчлөгдөөд байна. Гадаад эдийн засаг талаас авч үзвэл АНУ, БНХАУ-ын хооронд үүссэн худалдааны маргаан намжих бодит нөхцөл үүсч, хоёр улс хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Мөн 2020 онд зэс, нүүрс гэх мэт манай улсын голлох экспортын барааны үнэ буурах дарамт бага, дэлхийн эдийн засаг 2020 онд 2019 оныг бодвол харьцангуй өндөр өсөлттэй байх зэрэг эерэг төсөөллийг ОУВС, Дэлхийн банк зэрэг байгууллагууд гаргаад байна.

Дотоод эдийн засаг талаас Монгол Улсын гадаад худалдаанд гарч буй эерэг өөрчлөлтүүд 2020 онд хадгалагдах, эдийн засгийн идэвхжил 2019 онтой ойролцоо байх, инфляци төв банкны зорилтот түвшинд хадгалагдах төлөвтэй байна. Үүнээс гадна 2020 онд Монголбанк ХАБ-тай байгуулсан своп хэлцлийн хугацааг сунгах, Засгийн газар гадаад өрөө дахин санхүүжүүлэх чиглэлээр ажилласнаар гадаад валютын дотоодын зах харьцангуй тогтвортой байна хэмээн харж байна.

Ярилцсанд баярлалаа.



ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ

(АМ.ДОЛЛАРААР, 31/1 ӨДРИЙН БАЙДЛААР)



DAVOS 2020

WORLD ECONOMIC FORUM

ДАВОС 2020 БА ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

Өнгөрсөн онд дэлхийн эдийн засагт чухал үйл явдал олон боллоо. 2019 онд томоохон эдийн засгуудын голлох үзүүлэлтүүд буурч, бараан дүр зураг давамгайлсан жил байв. Тэгвэл 2020 онд эдийн засаг хэрхэх вэ гэдэг таамаглалуудыг эдийн засагчид болон шинжээчид дэвшүүлж байна. Мэдээж ОУВС, Дэлхийн банк зэрэг нөлөө бүхий олон улсын санхүүгийн байгууллагууд өөрсдийн төсөөллөө хийсэн хэдий ч бодит нөхцөл байдал төсөөллөөс зөрж эхэллээ. Харин Давос-2020 дээр асуудлыг хэрхэн авч үзсэнийг та бүхэнтэй хуваалцъя.



Хүртээмжтэй капитализм

Швейцарын Альпын нуруунд жил бүр болдог Дэлхийн эдийн засгийн форум нь 1-р сарын 21-24-ний өдөр болж өнгөрлөө. Энэ удаагийн уулзалт нь үндсэн 7 сэдвийн хүрээнд өрнөсөн бөгөөд тэдгээрийн нэг нь “Шударга эдийн засаг буюу хүртээмжтэй капитализм” юм. Капитализм гэдэг ойлголт нь дийлэнхдээ сөрөг талаас ойлгогддог. Капитализмын үндэс суурь нь хувийн өмч бөгөөд өмчийг зөвхөн эзэмшигч нь ихэвчлэн эргэлтэд оруулж,

ашиг олдог учраас нийтийн зүгээс ийм хандлагатай байх нь арга ч үгүй биз. Тэгвэл үүнийг өөрчилж, stakeholder буюу нийгмийн бүх оролцогч талуудад хүртээмжтэй болгохыг Давосын форум уриалж байгаа аж. Компаниудын хувьд эзэд нь ашгийг хамгийн өндөр түвшинд байлгаж, хувьцааны үнийг өсгөхийн тулд ажиллахаас гадна ажилтан, албан хаагчид, харилцагчид, нийгмийн бусад хэсэгт эерэгээр нөлөөлж, ашгаа хүртээх хэрэгтэй гэсэн үг.

Давосын үеэр АНУ-ын Дельта Эйрлайнсын гүйцэтгэх захирал “компаниудын үйл ажиллагааны ашгийн 90 орчим хувь нь хувьцаа эзэмшигчдэд төвлөрсөөр байгаа. Тиймээс энд эсвэл өөр уулзалтуудад ч тэр орлогыг тэгш хуваарилах дээр асуудал хөндөж, өөрчлөлтийг бий болгож байгаа нь сайшаалтай юм” гэжээ. Ерөөс ДНБ зэрэг эдийн засгийн индикаторуудыг илүү бодитой болгохын тулд нэг хүнд ногдох болон худалдан авах чадвар (PPP)-д харьцуулж тооцдог билээ. Нэг хүнд ногдох ДНБ нь үндсэндээ эдийн засгийн бүтээмжийг иргэн тус бүрт хувааж байгаа, амьдралын чанарыг харуулахыг эрмэлздэг. Харин худалдан авах чадварт харьцуулсан ДНБ нь тухайн улсын амьдралын өртөг буюу бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг багтааж тооцдог гэдэг утгаар илүү хүртээмжтэй байдалд ойртож болох юм.

Энэхүү форумыг угтаж ядууралтай тэмцэж, шударга худалдаа, орлогын тэгш хуваарилалтыг уриалдаг Оксфам байгууллагаас “Time to care” нэртэй судалгааг явуулж, тайлагнажээ. Уг тайланд тусгагдсан зарим чухал тоон үзүүлэлтүүдээс дурдвал: 2019 оны байдлаар дэлхийн хамгийн баян 22 хүний хөрөнгө Африк тивийн нийт эмэгтэйчүүдийн хөрөнгийн дүнтэй дүйж байна; дэлхийн хамгийн баян 75 орчим сая хүн буюу нийт хүн амын 1%-ийн эзэмшиж буй хөрөнгө нь үлдсэн 6.9 тэрбум жирийн иргэдийн хөрөнгөтэй тэнцэнэ; цалингүй ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн хийж байгаа ажилд нь зохих цалин хөлсийг тооцож олгоно гэвэл жилдээ \$10.8 их наяд доллар шаардагдахаар байгаа аж. Тэгэхлээр хүн ам зүйн өөрчлөлттэй зэрэгцээд эдийн засгийн

чухал сэдэв нь хүртээмжтэй байдлыг хэрхэн бий болгох вэ гэдэг юм.

Дэлхийн эдийн засгийн форум энэ жил 50 дахь удаагаа зохион байгуулагдсан бөгөөд орлогын тэгш хуваарилалтаас гадна уур амьсгалын өөрчлөлт, Ойрх дорнодод өрнөөд байгаа хурцадмал байдал гэх зэрэг асуудлыг хэлэлцлээ. 50 жилийн тэртээ дэлхийн улс орнуудын харилцаа тэс өөр, хүйтэн дайн тэр дундаа Вьетнамын дайн болж байсан үе. Тухайн үед нийгмийн байгуулалтууд ондоо, дэлхийн эдийн засагт тулгараад байсан асуудлууд ч өөр байв. Дэлхийн эдийн засгийн форум гэдэг энэхүү байгууллага нь өөрөө төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангах зорилготой аж. Энэ ч утгаараа дэлхийн төр, бизнес, судалгааны орой болсон хүмүүс чуулдаг. Хэдийгээр араасаа шүүмжлэлүүдийг дагуулдаг ч тус форум нь өнөө цагийн хамгийн үр өгөөжтэй, олон талт хамтын ажиллагааг хангадаг уулзалт болон өргөжжээ. 50 жилийн хугацаанд дэлхийн эдийн засагт тулгараад байгаа асуудлууд өөрчлөгдөж ирсэн, цаашид өөрчлөгдсөөр байх ба тэдгээрийг шийдвэрлэх гарц нь яах аргагүй хамтын ажиллагаа юм.

2020 онд дэлхийн эдийн засаг

Дэлхийн эдийн засгийн форумын үеэр уламжлал болон хэлэлцдэг сэдэв бол яах аргагүй тухайн жилийн эдийн засгийн төлөв юм. Ялангуяа энэ үеэр ОУВС-аас дэлхийн эдийн засгийн төлөв хэмээх тайлангийн 1-р сарын дугаараа гаргаж, танилцуулдаг. Тэгвэл ОУВС-ийн таамаглалаар 2020 онд дэлхийн эдийн засаг 2019 оныхоос илүү өсөлт үзүүлэхээр байгаа аж. Гэхдээ тэд өнгөрсөн 10 сард гаргасан тайлангийн төсөөллөө бууруулж 2019 оны гүйцэтгэлийг 2.9%, 2020 онд 3.3%, 2021 онд 3.4% өснө гэж тус тус тооцоолжээ. 2019 болон 2020 оны төсөөллийг 0.1%-аар тус тус бууруулсан гол шалтгаан нь хөгжиж байгаа эдийн засагт 2019 оны 2-р хагаст үйлдвэрлэл, худалдааны талаас сөрөг өөрчлөлтүүд бий болсноос үүдэлтэй. Ялангуяа дэлхийд 5-д жагсаж байгаа Энэтхэгийн эдийн засгийн өсөлт жилийн дотор 8%-аас саарч 4.5% хүрсэн явдал нь төсөөлөлд нөлөөлснийг ОУВС дурджээ. Мөн Каррибийн шуурга, Австралийн ойн түймэр, Зүүн Африкийн үер,

Өмнөд Азийн ган зэрэг байгалийн гамшиг тохиолдсон нь тухайн бүсүүдэд оршдог эдийн засгуудад дарамтыг бий болгосон. ОУВС-ийн ерөнхий эдийн засагч Гита Гопинат “цаашид өсөлт сэргэх эсэх төсөөлөл нь тодорхойгүй хэвээр байгаа бөгөөд хөгжингүй эдийн засгууд тогтворжлоо ч хөгжиж байгаа эдийн засгууд сэргэх, өсөхөөс голлон хамаарна” гэжээ. Өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлт нэмэгдэхэд өндөр хөгжилтэй орнууд бус Хятад, Энэтхэг, Бразил, Мексик зэрэг хөгжиж байгаа орнууд чухал нөлөөтэй юм.

Нөгөө талаас, дэлхийн эдийн засагт эерэг хүлээлтийг бий болгосон томоохон үйл явдал бол худалдааны маргаан шийдэлд хүрч, БНХАУ болон АНУ хоёр улс хэлэлцээрийн эхний гэрээнд гарын үсэг зурлаа. Ийнхүү тодорхой бус байдал буюу эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж байсан эрсдэл нэгээр цөөрч байгаа юм. Цаашлаад Брекситийн хугацаа тулж, хэд хэдэн удаа сунгасан ба хэлэлцээргүйгээр өндөрлөх эрсдэлтэй байсныг сонгууль зарлаж, Консерватив нам шийдвэрт хүрэхүйц түвшинд суудалтай болсноор энэхүү эрсдэл буурч байна. ОУВС-аас хөгжиж буй орнуудын Засгийн газар, Төв банкинд өгөх зөвлөмждөө “Гадаад өрийн дарамт ихтэй улс орнууд гадаад зах зээлд гарч буй өөрчлөлтүүдийг анхааралтай ажиглаж бодлогоо уялдуулах, нөөцийг хуримтлуулах, эдийн засгийн огцом өөрчлөлтөд бэлэн байх, үүний тулд татаас, халамжийг оновчтой болгох, орлогын суурийг нэмэгдүүлэх нь зүйтэй” гэж зөвлөжээ.

Улс орнуудын эдийн засаг

БНХАУ-ын эдийн засаг 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6.1 хувиар өслөө. Энэ нь өмнөх оныхоос буурсан үзүүлэлт ба Засгийн газрын зорилтот 6.5%-аас бага түвшин юм. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 1991 оноос хойш тогтмол 6%-аас дээш өсөлттэй байсан бөгөөд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ \$10,276 ам долларт хүрчээ. ОУВС-аас БНХАУ-ын өсөлтийг 2020 онд 6.0%, 2021 онд 5.8%-д хүрэх прогноз гаргаж байна. Худалдааны маргаан шийдвэрлэгдэх хандлагатай болсноор төсөөлөл дээр +0.2%-ийн өөрчлөлт гарах боломжтой аж.

ОХУ-ын хувьд эдийн засгийн өсөлт 3-р улирлын байдлаар 1.1%-д хүрсэн бөгөөд жилийн эцсийн гүйцэтгэлээр энэ түвшин 1.3%-д хүрч өсөх хандлагатай байна. Оросын Төв банкнаас өсөлтийг 2020 онд 2-3 хувийн хооронд байхаар таамаглаж байгаа бол ОУВС-аас 1.9%, улмаар 2021 онд 2.0% хүрнэ гэж үзэж байгаа ба 10 сарын төсөөлөлд өөрчлөлт ороогүй байна. АНУ-ын өсөлт 2019 онд 2.3%-д хүрэхээр байгаа бол 2020 оны төсөөллийг 0.1% бууруулж 1.3% байхаар тооцож байна. Ази бүсийн хөгжиж байгаа эдийн засгийн өсөлт 2019 онд 5.6%, 2020 онд 5.8%-д хүрэхээр байна. Монголын эдийн засгийн өсөлтийг ОУВС-ийн таамгаар 2020 онд 5.4%, Дэлхийн банк 5.5%, АХБ 6.1% байхаар тооцоолж байна. Харин Монголбанкнаас ДНБ-ий өсөлтийг 2020 онд 3.7%-7.5% байх төсөөлөлтэй байгаа ба үүнд уул уурхайн салбар 0.9%-4.7%, уул уурхайн салбар 4.5%-8.3% өсөх тооцоотой байна.

Эх сурвалж:

<https://www.weforum.org/events/world-economic-forum-annual-meeting-2020>

<https://www.cnn.com/2020/01/20/davos-imf-world-economic-outlook-january-2020.html>

<https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2020/01/20/weo-update-january2020>

<https://www.mongolbank.mn/documents/statistic/inflationtuluv/2019Q4.pdf>

САЙЖРУУЛЖ ШИНЭЧИЛСЭН 50, 20000 ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТҮҮД

Мөнгөн тэмдэгтийг хэрэглээнийх нь явцад эдэлгээ даах чанарыг нь сайжруулах, хуурамчаар үйлдэхээс сэргийлсэн хамгаалалтын элементүүдийг нь нарийвчлан боловсронгуй болгох, түүнчлэн загвар, дүрслэл дээр нь ч дахин ажиллах шаардлага гардаг. Тийм ч учраас мөнгөн тэмдэгтүүд шинэчлэгддэг.

Монголбанк энэ удаад 50, 20000 төгрөгийн дэвсгэртүүдийг хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологиор сайжруулан гүйлгээнд нэвтрүүллээ.

Шинэчлэгдсэн мөнгөн дэвсгэртүүдийн хамгаалалтыг хэрхэн сайжруулсантай танилцана уу.

50 ТӨГРӨГ

Усан хээг мөн адил сайжруулсан бөгөөд дэвсгэртийг гэрлийн эсрэг барихад Чингис хааны хөрөг болон МБ гэсэн үсэгтэй усан хээ тод харагдах болно.



Энэхүү дэвсгэртийн нүүрэн тал баруун доод булан дахь хээн дээр байрлуулсан 50-ын араб тоо бүхий өнгө нь хувирагч шинэ элементтэй болсон бөгөөд энэ нь 3-н хэмжээст, хөдөлгөөнтэй, дээш, доош налуу хөдөлгөхөд цаад гүн хэсэгт байх 2 цагираг шар болон ногоон өнгөөр ээлжлэн солонгорч харагдана.

Түүнчлэн харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан шинэ элементийг дэвсгэрт дээр нэмж оруулав. Баруун, зүүн ирмэг дэх 2 ширхэг ташуу товгор зураас нь 50-тын дэвсгэртийг илэрхийлэх бөгөөд хурууны үзүүрт тэмтрэгдэнэ.

20000 ТӨГРӨГ

Усан хээ нь нягтаршил сайтай болсон бөгөөд гэрлийн эсрэг барихад Чингис хааны хөрөг, МБ гэсэн дүрсүүд тод харагдана.

20000-тын дэвсгэртийн нүүрэн тал 4 морьтон баатрын дүрс бүхий өнгө нь хувирагч шинэ элементтэй болсон бөгөөд энэ нь 3-н хэмжээст, хөдөлгөөнтэй, дээш, доош, баруун, зүүн тийш хөдөлгөх зэргээр харах өнцгийг өөрчлөхөд цаана гүн хэсэгт байх 2 цагираг шар болон ногоон өнгөөр ээлжлэн солонгорч харагдана.

Баруун, зүүн ирмэг дэх 8 ширхэг ташуу товгор зураас нь 20000-тын дэвсгэртийг илэрхийлэх Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан элемент бөгөөд хурууны үзүүрт тэмтрэгдэнэ.



Түүнчлэн 20000-тын дэвсгэрт маань хамгийн сүүлийн үеийн технологиор хийсэн хөдөлгөөнт гадаргуутай цоо шинэ туузтай болсон бөгөөд энэхүү элемент нь соёмбо, өлзий хээ, арга билиг, алхан хээ, Монголбанк гэсэн бичил текстүүдийг дотроо агуулсан 3 хэмжээстэй микро оптик, хөдөлгөөнт гадаргуу юм. Дэвсгэртийг дээш, доош, баруун, зүүн тийш налуу хөдөлгөхөд эдгээр дүрс нь нэгэн зэрэг олон тийш чиглэлтэй хөдөлгөөн илрэхийн зэрэгцээ зарим дүрсүүд нь цаад гүн хэсэгт харагдана.

Туузны доторх цаад гүн хэсэгт алхан хээ, арга билиг дүрсүүд харагдана.

Дэвсгэртийг 2 тийш налуу хөдөлгөхөд Соёмбо доторх оптик линзээр хийсэн нарны бэлэгдэл дотор арга билиг томорч харагдан хөдөлнө.

Түүнчлэн арга билиг дотор эсрэг хоёр чиглэлтэй тойрог хөдөлгөөн харагдахын зэрэгцээ хөндлөн ба босоо судлууд дээш доош баруун, зүүн тийш нэгэн зэрэг байршлаа сольж эргэлдэнэ.

Соёмбоны суурь бадамлянхуа цэцгийн доторх хөндлөн 2 судал нь төв рүүгээ салж, нийлж харагдана.

Өлзий хээ доторх хөдөлгөөнт судлууд үелээж харагдана.

ГЯЛГАР СУДАЛ

Дэвсгэртийн ар талын баруун хэсэгт дээш, доош налуу хөдөлгөхөд боронзон шаргал өнгөөр гялалзах өлзий хээг харж болно.

Эдгээр хамгаалалтын таних тэмдгүүдийн тусламжтайгаар жинхэнэ мөнгөн дэвсгэртийг хуурамчаас хялбархан ялгаж таних боломжтой боллоо.



Дэлхийн Банкны Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийг хариуцсан Дэд Ерөнхийлөгч, Виктория Кваква

ВИКТОРИЯ КВАКВА: МОНГОЛ УЛС УРТ ЗАМ ТУУЛЛАА – ОДОО ЭДГЭЭР ОЛОЛТЫГ БЭХЖҮҮЛЭХЭД ЮУ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Дэлхийн Банкны Зүүн Ази, Номхон Далайн бүс нутгийг хариуцсан Дэд Ерөнхийлөгч, хатагтай Виктория Кваква Монголын эдийн засгийн нөхцөл байдлын талаар өөрийн сэтгэгдэл бүхий нийтлэлийг Дэлхийн банкны цахим хуудаснаа ийн нийтлэжээ.

Эдийн засгийн тогтвортой сэргэлтийг хадгалахын тулд эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэсэн оновчтой менежмент хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Намайг хамгийн сүүлд 2016 онд Монгол Улсад айлчилж байх үед тус улсад эдийн засгийн гүнзгий хямрал, төсвийн ихээхэн алдагдал, тогтворгүй өндөр өр нүүрлэсэн байлаа. Түүнээс хойш гайхалтай сайн өөрчлөлтүүд бий болжээ. Үүнд чухал нөлөө үзүүлсэн нэг хүчин зүйл нь Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг олон улсын байгууллагууд, түншүүдийн дэмжлэгтэйгээр Засгийн газраас хэрэгжүүлж, хүчин чармайлт гаргасан явдал бөгөөд үүнд талархууштай юм.

2017 оноос хойш эдийн засгийн өсөлт дунджаар 6.5 хувьтай байсан ба 2016 онд төсвийн алдагдал ДНБ-ний 15.3 хувьд хүрээд байсан нь эрчтэй буурч харин эсрэгээрээ өнгөрсөн онд 2.6 хувийн ашигтай гарч, өрийн хэмжээ буурчээ. Гэхдээ өрийн хэмжээ өндөр хэвээр байгааг хэлэх нь зүйтэй.

Дэлхийн банк энэхүү ахиц дэвшлийг нөхцөлдүүлэхийн тулд төсвийн алдагдлыг нөхөх, нийгмийн халамжийн зарцуулалтыг сайжруулах, хувийн хэвшлийн ажлын байрыг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалтын орчныг бэхжүүлэх зорилт бүхий төсвийн хоёр арга хэмжээг авч хэрэгжүүлэн, дэмжлээ. Олон улсын санхүүгийн корпораци болон Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах олон талт агентлаг дахь бидний хамтран зүтгэгчид нар санхүүгийн болон уул уурхайн салбарт хамтран ажиллаж, энэхүү ахиц дэвшилд хувь нэмрээ оруулсан.

Дэлхийн орлого багатай орнуудад хөнгөлөлттэй санхүүжилт олгодог Дэлхийн Банкны Группын Олон улсын хөгжлийн ассоциацаас Монгол Улс удахгүй ахиж дунд орлоготой улс орны статустай болж байгаа нь Монгол Улсын хөгжлийн чиг хандлагад итгэх итгэлийг бататгалаа.

Эдгээр ахиц, дэвшилд хүрсэн ч гэлээ цаашид хийх зүйл их байна. Олон улсын төлөв байдал улам бүр тогтворгүй, эргэлзээтэй болж байгаа энэ үед тууштай байдлыг хангаж, бодлогын өөрчлөлтөөс зайлсхийж, шаардлагатай шинэчлэл хийхэд олон нийтийн зүгээс өргөнөөр дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна. Одоогийн байдлаар гурван гол эрсдэл тулгараад байгааг онцолъё.

Нэгдүгээрт, ядуурал өндөр хэвээр байна. Үндэсний статистикийн хорооны урьдчилсан

тооцооллоос үзэхэд хотын ядуурлын түвшинд ахиц гарахаа больж, зогсонги байдалд хүрчээ. Нөгөө талаас махны үнэ өндөр байгаа нь малчид, хөдөө орон нутгийн иргэдэд эерэгээр нөлөөлж байгаа хэдий ч уул уурхай болон үйлдвэрлэлийн салбарын ашиг нь нийгэмд хүртээмжтэйгээр очихгүй, тэр дундаа хотын хүн амын дийлэнхэд нь орлогын боломжийг бий болгож, хүрэхгүй байна. Тиймээс илүү их, илүү сайн ажлын байр бий болгох нь нэн тэргүүний зорилт хэвээр байна.

Хоёрдугаарт, иргэдийн амьжиргааны түвшинг тогтвортойгоор сайжруулахын тулд институцүүдийг илүү хүчтэй болгож, засаглалыг сайжруулах хэрэгтэй байна. Энэ нь хувийн хөрөнгө оруулагчдын итгэлийг улам нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг илүү чанартай болгох чухал ач холбогдолтой юм.

Гуравдугаарт, санхүүгийн салбар болон улс орны гадаад тэнцвэр нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдлын “Ахиллесийн өсгий” буюу сул тал болсон хэвээр байна.

Эдгээр эрсдэлийг арилгах, өсөлт-уналтын мөчлөгийг зогсоохын тулд бодлого боловсруулагчид юу хийж чадах вэ?

Засгийн газраас шинэчлэлийн чиг хандлагаа хадгалах хэрэгтэй. Ингэхдээ хувийн сектор ажлын байр, өндөр орлого олох боломжийг бий болгох үйл ажиллагаанд илүү их анхаарлаа төвлөрүүлэх ёстой ба төсвийн аливаа шахалтаас зайлсхийж, өмнөх алдаатай туршлагаа давтахгүй байх хэрэгтэй. Үүнд хүрэхийн тулд хөрөнгө оруулалтын орчин ил тод, урьдчилан таамаглаж болохуйц байвал зохино.

Ядуу, эмзэг өрхүүдийг хамгаалж, дэмжих хэрэгтэй. Үүний тулд нийгмийн хамгааллын системийг улам боловсронгуй болгож, халамжийн бодлогыг илүү оновчтой чиглүүлэх боломжтой. Төсвийн алдагдалд нөлөөлөөд байгаа тэтгэврийн тогтолцооны талаар мөн арга хэмжээ авах хэрэгтэй. Үүнд илүү зоримог шинэчлэл шаардлагатай болов уу.

Санхүүгийн сектор тулгараад буй эрсдэлийг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

ОУВС-тай тохиролцсоны дагуу банкны салбарыг амжилттай дахин хөрөнгөжүүлэх нь болзошгүй гадаад сөрөг цочролын үед санхүүгийн тогтвортой байдлыг хангах юм. Монгол Улс энэ асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх хэрэгтэй. Санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын “Саарал жагсаалт”-аас гарахын тулд Монгол Улс мөнгө угаахтай тэмцэх асуудлаа шийдвэрлэвэл зохих ба энэ нь олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас санхүүжилт татах боломжийг хадгалах юм.

Эцэст нь хэлэхэд, Монголбанк валютын ханшийг илүү уян хатан болгож, интервенцийн хэмжээг хязгаарлах боломжтой. Эдийн засаг харьцангуй тогтвортой хэвээр байгаа энэ үед валютын ханшийн уян хатан байдалд хадгаламж эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдыг дасгах хэрэгтэй юм.

Сүүлийн гурван жилийн хугацаанд олсон ололт амжилтыг үндэслэн эдгээр бэрхшээлийг шийдвэрлэхэд олон улсын байгууллага, орнууд нь Монгол Улсад дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна. 1991 оноос хойш Дэлхийн банк нь Монгол Улсын байнгын түнш байсан бөгөөд нэг тэрбум гаруй ам.долларын санхүүжилтийг олгожээ.

Бид дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, засаглалыг сайжруулах чиглэлээр хөрөнгө оруулалтуудыг хийж ирсэн. Өнөөдрийг хүртэл гаргасан ахиц дэвшлийг бид өндрөөр үнэлж байгаа ба ард иргэдийнхээ амьжиргааны түвшинг дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй, дундаж орлоготой улс орон болох зорилт бүхий Монгол Улстай түншлэлийн харилцаагаа улам бэхжүүлнэ гэж найдаж байна.

Монгол Улс урт замыг тууллаа.

Эдгээр үр дүнг хамтдаа бэхжүүлье.

МОНГОЛ УЛСЫН ЭРДЭС БАЯЛГИЙН ОРЛОГЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД

Азийн Хөгжлийн Банкнаас бэлтгэн гаргадаг “Ажиглалт ба санал — бодлогын зөвлөмж” цувралын сүүлийн дугаарт хэвлэгдсэн, эрдэс баялгийн орлогын менежментийг сайжруулах замаар Монгол Улсын макро эдийн засгийн тогтвортой байдлыг хэрхэн хангаж болохыг өгүүлсэн бодлогын тайлбар бичгийг Та бүхний анхааралд толилуулж байна.

*Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банкны
Улаанбаатар дахь Суурин төлөөлөгчийн газар*

I. УДИРТГАЛ

1. Төсвийн орлого, зарлагыг удирдах нь аливаа Засгийн газрын нэн тэргүүний үүрэг байдаг. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгаас эх үүсвэртэй орлогын хувьд тодорхой хязгаартай, аль нэг байршилд уягдсан, их хэмжээний огцом ашиг бий болгохын зэрэгцээ тухайн орны эдийн засагтай харьцуулахад хэмжээний хувьд үлэмж бөгөөд тогтворгүй байдгаараа онцлогтой билээ. Ийм нөхцөлд байгалийн баялгаас хэт хамааралтай төсвийн орлогыг зөв зүйтэй удирдаагүй тохиолдолд тухайн эдийн засаг нь мөчлөг дагасан савлагаа, авлига, “Голланд өвчин”-д¹ нэрвэгдэх хор уршигтай юм.

2. Монгол Улсын уул уурхай, ашигт малтмалын салбар 2000 оны эхэн үеэс эхлэн хурдацтай өсөн тэлж, тус салбар өдгөө эдийн засагт давамгайлж, экспортын 90 хувийг бүрдүүлж байна. Монгол Улсын хувьд төсвийн нийт орлогын 24 хувийг ашигт малтмал, уул уурхайн салбарын татварын болон татварын бус орлогоос бүрдүүлж байна. Мөн орлогын албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татварыг тус салбараас төвлөрүүлж

байна.² Гэхдээ бодлогын хэрэгжилт сул байснаас төсвийн алдагдал, өрийн ачаалал нэмэгдсээр иржээ. Эрдэс баялгийн орлогын төвлөрүүлэлтийг хэд хэдэн төрийн байгууллага хариуцаж, орлогын урсгалыг төвийн болон орон нутгийн захиргааны түвшинд хэт олон байгууллага татан төвлөрүүлж байгаа нь татвар хураах үйл ажиллагааг төвөгтэй болгож, үр дүнг нь сулруулж байна.

3. Эдгээр хүндрэл бэрхшээлийг авч үзвэл, Монгол Улсын байгалийн баялгийн орлогын менежментийг сайжруулах нь ирээдүйн хүртээмжтэй өсөлтийг хангахад амин чухал болоод байна. Монгол Улс үлэмж хэмжээний эрдэс баялгаа үр дүнтэй удирдахад нь дэмжлэг болох, олон улсын шилдэг туршлагад тулгуурласан зөвлөмжийг Та бүхний анхааралд толилуулж байна.

II. ЭРДЭС БАЯЛГИЙН ОРЛОГЫН МЕНЕЖМЕНТ БА БОДЛОГЫН СОРИЛТ

1. Мөчлөг дагасан савлагаанаас эдийн засагт үзүүлж буй нөлөөг саармагжуулах үүднээс шийдвэр гаргагчид 2010 оноос хойш олон төрлийн санаачлагыг авч хэрэгжүүлж эхэлсэн байна. Гэвч төсвийн бодлого, дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй, төсвийн сахилга бат муу байснаас зорьсон үр дүнд хүрээгүй нь улмаар төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, өнөөгийн өрийн их дарамт, зогсолтгүй давтагдах эдийн засгийн бууралтын суурийг тавьсан билээ.

2. Төсвийн дүрэм журмын хэрэгжилт сул байна. Хуулийн хүрээнд төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн өнөөгийн цэвэр үнэ цэнийн дээд хязгаарыг тогтоосон төсвийн тодорхой дүрмийг зүйлчилсэн байдаг. Гэсэн хэдий ч эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийн улмаас төсвийн алдагдал ихсэн, өр нэмэгдсэн тул тогтоосон дүрэм, журмаа удаа дараа залруулж, шаардлагыг нь зөөллөжээ.

3. Үндэсний баялгийн сан олшрох төлөвтэй байна. 2016 онд Ирээдүйн өв сан (ИӨС)-гийн

¹ Голланд өвчин гэдэг нь эдийн засаг их хэмжээний дотоод зарлага гаргаснаас үүдэн худалдаалах боломжтой нөөцөөс худалдаалах боломжгүй нөөц рүү шилжих үед төрдөг ойлголт юм. Энэ нь валютын ханшийг өсгөснөөр экспортын өрсөлдөх чадварыг бууруулдаг.

² Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам. 2018 он. 2019 оны улсын төсвийн төсөл. Улаанбаатар хот.

тухай хуулийг баталж, орлогын эх үүсвэрийн талаарх хоёрдахь дүрмийг тодорхойллоо. Энэхүү хуульд зааснаар, хойч үедээ зориулж уул уурхайн орлого болон нөөц ашиглалтын төлбөрийн тодорхой хувийг шинээр байгуулагдсан үндэсний баялгийн сан болох ИӨС-д төвлөрүүлэх нь Хүний хөгжлийн сангийн өр 2019 онд төлөгдөж дууссаны дараа эхлэхээр төлөвлөгдсөн билээ. ИӨС байгуулагдсанаас хойш дахин хэд хэдэн үндэсний баялгийн санг байгуулах санаачлага мөн гарч байжээ. Олон сан шинээр байгуулах нь орлогын удирдлагыг төвлөрсөн бус болгож, засаглал болон хөрөнгийн хяналтыг хүндрүүлэх уршигтай юм.

4. Төсвийн сахилга бат сул байна. Төсвөөс гадуурх болон төрийн өмчит байгууллагын зардал нэмэгдсэн нь төсвийн холбогдолтой дүрэм, журмын сул хэрэгжилтийн үр дагаврыг улам даамжруулсан байна. Үүнд Засгийн газрын баталгаатай зээлийн эх үүсвэрийг төслийн санхүүжилтэд зарцуулсан Монгол Улсын Хөгжлийн банк болон үнэ тогтворжуулах хөтөлбөрийг санхүүжүүлсэн Монголбанк зэргийг дурдаж болно. 2017 оноос эхлэн төсвийн сахилга бат үлэмж сайжирснаар Монгол Улсын Засгийн газрын өрийн ачаалал хөнгөрч, Төв банкны өрийг багтаасан улсын нийт өр хоёр хүрэхгүй жилийн дотор 25 нэгж хувиар буурчээ. Гэсэн хэдий ч эдийн засгийн энэхүү сэргэлт нь гадаад цочрол, нэн ялангуяа түүхий эдийн үнийн уналтын нөлөөлөлд эмзэг хэвээр байна.

5. Эдийн засгийн уналт давтагдсаар байна. Бодлогын алдаа, дутагдлын улмаас улсын төсвийн зарлага нь эрдэс баялгийн түүхий эдийн үнийн өөрчлөлтийг дагаж савласаар байна. Орлогын төвлөрүүлэлт тогтвортой бус нөхцөлд хэт үрэлгэн төсөв баталж, хэрэгжилт нь доголдолтой томоохон дэд бүтцийн төслүүдийг эхлүүлсэн нь түүхий эдийн үнэ унах үед Засгийн газрын өрийг үлэмж хэмжээгээр өсөхөд хүргэжээ.

Монгол Улсын газар зүйн байрлал, хөрөнгө, санхүүгийн хязгаарлагдмал байдлыг харгалзаж үзвэл тогтвортой хөгжлийг цогцлоохын тулд төрөөс томоохон хөрөнгө оруулалт (голчлон дэд бүтцэд)-ыг хийх шаардлагатай бөгөөд үүнийг эрдэс баялгийн орлогоор санхүүжүүлэх боломжтой юм.

Ойрын хугацаанд хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ

1. Төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх. Төрийн бүх зарлагыг улсын төсөвт нэгтгэж, орлогын удирдлагын төвөгтэй тогтолцоог хялбаршуулах нь төсвийн зарцуулалтыг оновчтой болгож, хяналтыг сайжруулахад дэмжлэг болно. Үүнийг хэрэгжүүлэх нэг арга зам нь төсвөөс гадуурх төрийн байгууллагын тоог цөөлж, зөвхөн төрийн санхүүгийн удирдлагын ил тод байдлыг хангах, иргэдийн итгэлийг бэхжүүлэхэд хэрэгтэй хэсгийг авч үлдэх явдал юм. Мэдээллийг хангалттай хэмжээнд нийтэд түгээх нь чухал ач холбогдолтой.

2. Улсын төсвөөс гадуурх шинэ сан байгуулахаас зайлсхийх. ИӨС-гийн тухай хуульд тухайн сангийн одоогийн хүчирхэг засаглалын зарчмыг өөрчилсөн нэмэлт, өөрчлөлт оруулахгүй байх нь зүйтэй. Төсвөөс гадуурх шинэ сан байгуулахын оронд төрийн санхүүгийн менежментийг сайжруулахад анхаарвал зохино. Уул уурхайн салбараас төвлөрүүлсэн орлогоор төсвийн хөрөнгө оруулалтыг шууд санхүүжүүлдэг сан ажиллуулах нь хөрөнгө оруулалтын төслийн чанар муу, хяналт сул байх суурийг тавьж, улмаар түүхий эдийн үнэ унах үед улс орныг санхүүгийн томоохон эрсдэлд оруулдаг аж. Засгийн газрын хувьд гадаад валютын активын урт хугацааны өгөөж нь гадаад өрийн хүүний төлбөрөөс өндөр байх үед валютын хуримтлалд анхаарах нь зүйтэй. Иймд Засгийн газрын өрийг даахуйц хэмжээнд багасгах нь нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх амин чухал алхам болно.

3. Засгийн газрын төсвийн зарцуулалтыг үндэсний болон эрдэс баялгийн салбарын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах. Төслийн

түвшинд эдийн засгийн өсөлтөд тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэж буй эсэх, эдийн засгийн кластерийн³ чухлыг тооцоолж буй эсэх, мөн хэрэгжүүлэхэд үр ашигтай эсэхийг нь тооцож үзсэний үндсэн дээр төслийг эрэмбэлэх журам хэрэгжүүлбэл зохино. Ингэхдээ иж бүрэн техник, эдийн засгийн үндэслэлийг төлөвлөлтийн эхний шатанд боловсруулахыг шаардсанаар шийдвэр гаргалтыг оновчтой болгож, төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг улс төрийн мөчлөгөөс тусгаарлах ач холбогдолтой юм.

4. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг бэхжүүлэх. Шинээр байгуулагдсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь өөрчлөлт, шинэчлэлд түлхэц өгөх боломжтой хэдий ч улс төрийн нөлөөлөл орж, бүрэн эрх нь хязгаарлагдмал байвал үр дүнд хүрэхгүй билээ. Иймд зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг баталгаажуулах, боловсон хүчин болон санхүүжилтээр хангах, улс төрөөс хараат бус, эсвэл олон намын дэмжлэг авсан гишүүдээс бүрдүүлэх зэргээр зөвлөлийн бие даасан байдлыг бэхжүүлж болно. Мөн түүнчлэн, холбогдох бүхий л төрийн баримт бичигтэй хязгаарлалтгүйгээр танилцах бүрэн эрхийг Засгийн газраас зөвлөлд олгох нь зүйтэй. Зөвлөл нь төсвийн орлогын төлөвлөлтийг сайжруулах зорилгоор төсвийн бие даасан төсөөлөл боловсруулах үүрэг хүлээвэл зохино.

Дунд болон урт хугацааны бодлогын арга хэмжээ

1. Төсвийн болон макро эдийн засгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Монгол Улсын төсвийн тогтвортой байдлыг хангах замын зураг болох төсвийн дүрмийг тодорхойлжээ. Өрийн дээд хязгаарын дүрэмд урт хугацаанд өрийн тогтвортой байдлыг хангах зорилтыг тодорхойлсон бөгөөд Монгол Улс өрийн зохицуулалт хийх, эсвэл төсвийн ашгийн эх үүсвэрээр эргэн төлөх замаар 2017 оноос хойш өрийн ачааллаа бууруулах тал дээр гаргасан ахиц дэвшил дээрээ дөрөөлөн энэхүү зорилтод хүрэх боломжтой юм. Засгийн газрын зүгээс ОУВС-ийн одоогийн

хөтөлбөр дуусгавар болох цаг үеийг Монгол Улсын ирээдүйн бодлогын орчинд макро эдийн засгийн оновчтой бодлогыг хэвшүүлэх боломж хэмээн харж, хэрэгжүүлэх нь чухал юм.

2. Эдийн засгийг төрөлжүүлэх. Эрдэс баялгаас хамаарал багатай, илүү төрөлжсөн эдийн засаг нь түүхий эдийн үнийн мөчлөг дагасан савлагаанд бага өртдөг. Ийм эдийн засаг нь хөрөнгө оруулалт их шаарддаг уул уурхайн салбарыг бодвол илүү хүртээмжтэй байж, монголчуудад илүү олон эдийн засгийн боломжийг олгоно. Монгол Улсын хөдөө аж ахуй болон аялал жуулчлалын тогтвортой салбар нь эдийн засгийг төрөлжүүлэх өндөр боломжтой салбар юм. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэхэд тогтвортой макро эдийн засгийн бодлого шаардлагатай бөгөөд энэ нь гадаадын хөрөнгө оруулагчдыг татахын зэрэгцээ Монгол Улсын үндэсний валют-төгрөгийн хөрвөх ханш өрсөлдөх чадвартай буюу экспортыг дэмжихүйц бодит үнэлгээтэй байх явдлыг хангана.

3. Орлогын хуваарилалтын бодлого болон тогтворжуулагч механизмыг сайжруулах. Өмнөх туршлагаас харахад, орлогын хуваарилалтын бодлого байхгүй нөхцөлд эдийн засгийн хурдацтай өсөлт нь орлогын тэгш бус байдлыг бий болгодог буюу даамжруулдаг байна. Иймд цаашид Монгол Улсад “автомат тогтворжуулагч” тогтолцоог нэвтрүүлснээр одоогийн төсвийн дүрмийн хэрэгжилтэд дэмжлэг болж, айл өрхүүдэд тулгарч буй эдийн засгийн эрсдэл болон тодорхой бус байдлыг бууруулан, улмаар дотоодын хэрэглээг хөхиүлэн дэмжих учиртай.

3 Газар зүйн нэг байршилд төвлөрсөн аж ахуйн нэгжүүдийн бүлэглэлийг эдийн засгийн кластер гэнэ.



ҮНЭМШИХЭД ХЭЦҮҮ ТӨГС ТӨГӨЛДӨР СОНСОГДОЖ БАЙВАЛ ЭНЭ НЬ ИХЭНХДЭЭ ХУДАЛ ГЭСЭН ҮГ!

САНХҮҮГИЙН ЗАЛИЛАН, ЛУЙВРЫГ ХЭРХЭН МЭДЭХ ВЭ?

- Танд хурдан хялбар аргаар мөнгө олохыг санал болгох;
- Таны хувийн болон банкны дансны мэдээлэл, нууц үг, PIN кодыг асуух;
- Таны өмнө нь сонсож, дуулж байгаагүй компани эсвэл үл таних хүнээс захидал, цахим шуудан, мессеж ирэх;
- Танд хангалттай хугацаа олгохгүй нэн даруй шийдвэр гаргах шахалт үзүүлэх;
- Танд санал болгосон зүйлээ нууцлахыг хүсэх;
- Урьдчилж мөнгө төлөхийг хүсэх гэх мэт.

ТА ГОМДОЛТОЙ БАЙВАЛ ЯАХ ВЭ?

- 01 Холбогдох бүх бичиг баримтаа цуглуулах
- 02 Банк, санхүүгийн байгууллагад гомдол гаргах, мэдэгдэх
- 03 Хуулийн байгууллагад хандах

САНХҮҮГИЙН ЛУЙВРААС ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ

- 01 Дансны мэдээлэл, карт, нууц үг, PIN кодоо бусдад өгөхгүй байх
- 02 Онлайн худалдан авалт хийхдээ болгоомжтой байх
- 03 АТМ-тэй сайн танилцах
- 04 Хувийн мэдээллээ найдвартай хадгалах

Хэрэв та санхүүгийн луйвар, залилангийн хохирогч болсон бол санаа зовох хэрэггүй. Энэ тухайгаа холбогдох газарт мэдээлэх хэрэгтэй. Ийнхүү мэдээлснээр та өөрийнхөө хохирлыг эргүүлэн олж авах болон бусад хүмүүсийг ижил төрлийн санхүүгийн луйвар, залилангийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд туслана.



www.mongolbank.mn
www.police.gov.mn
www.sankhuugiinbolovsrol.mn

Залилах гэмт хэрэг жилд 600
бүртгэгддэг байсан бол
2019 онд 4600 болж өсжээ!



ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ

залилагчдад боломж бүү олго!

ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ

залилагчдад боломж бүү олго!



2011 онд залилах гэмт хэрэг
688 бүртгэгдсэн
2019 онд 4600 болж өссөн.

Цахим орчинд ирсэн
ойлгомжгүй линк дээр
дарвал та бүх мэдээллээ
алдаж залилуулна!




ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ

залилагчдад боломж бүү олго!



Гадаад улсын визийг зөвхөн
тухайн улсын элчин сайдын яамны
төлөөлөгчийн газар гаргадаг



ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ



Залилагч гэрээ хийж,
нотариатаар батлуулсны
дараа мөнгөө аваад
алга болдог



ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ

залилагчдад боломж бүү олго!

залилагчдад боломж
бүү олго!

Бусдын гуйлтаар банкны
карт болон дансаа
ашиглуулж болохгүй.



ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ